



Implemented by:



Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага хөтөлбөр
Integrated Mineral Resource Initiative

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог нэвтрүүлэх аргачлал



Implemented by:



Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага хөтөлбөр
Integrated Mineral Resource Initiative

Эрхлэн гаргасан:

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн (ГОУХАН)
Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага (ЭТИС) хөтөлбөр

Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Нэгдсэн Үндэсний гудамж 38-р байр, 3 давхар
210236 Монгол Улс, Улаанбаатар хот

Утас: +976 7011 7704
Факс: +976 7011 7705
И-мэйл: imri@giz.de
Вэб: www.giz.de, www.imri-mn.com
Зураг: © GIZ, CBM

Энэхүү аргачлалыг ГОУХАН-ийн “Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага хөтөлбөр”-ийн захиалгаар германы зөвлөх компани СиБиМ ХХК (CBM) гүйцэтгэв.

Редакторын тэмдэглэл

Энэхүү толилуулж буй аргачлал нь ХАБЭА-н удирдлагын тогтолцооны бүтэц, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх арга замыг дүрслэн үзүүлсэн болно. Үүний тулд германы ХАБЭА-н туршлагыг олон улсын стандартын хамт ашигласан. Эл аргачлалын бүтэц болон хэрэгжүүлэх алхмыг ерөнхийдөө бусад бүх салбарт нийцүүлэн хэрэглэх боломжтой. Гэхдээ энэхүү хувилбарыг монголын уул уурхайн салбар, түүний олон талын онцлог, учирж болзошгүй аюул эрсдэл болон бүтэц зохион байгуулалтын шинж тэмдгийг харгалзан боловсруулсан юм.

Өмнөх үг

Эрхэм ноёд, хатагтай нараа.

Монгол Улсын Хөдөлмөрийн яам хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн бодлого, хууль тогтоомж, холбогдох журам, стандарт, үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах асуудлыг үндэсний хэмжээнд хариуцан ажиллаж байна.

Эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н үр нөлөө бүхий удирдлагын тогтолцоог /менежментийг/ төлөвшүүлэхэд бидний хамтын ажиллагаа ихээхэн ач холбогдолтой бөгөөд үр дүнгээ өгч байгаа билээ.

Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд “хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, өвчлөлөөс ажилтныг хамгаалах ХАБЭА-н менежмент нэвтрүүлэх” –ийг ажил олгогчийн үүрэг болгон хуульчилж өгсөн. Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэхэд Герман улсын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компаниас сүүлийн үеийн ХАБЭА-н туршлага, ололт, олон улсын стандартад түшиглэн боловсруулж гаргасан “ХАБЭА-н удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх аргачлал” ихээхэн хувь нэмэр оруулна гэж дүгнэж байна.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрөөс санаачлан боловсруулсан энэхүү аргачлалыг Хөдөлмөрийн яамны бүтцийн нэгж болох аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөрийн хэлтсүүдээр дамжуулан аж ахуйн нэгж, байгууллага, компаний үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглах нөхцлийг бүрдүүлж ажиллахад анхаарах болно.

ХАБЭА-н менежмент нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах нь тухайн аж ахуйн нэгж, байгууллага, компаний ХАБЭА-н алба, хэлтэс, ажилтны хариуцан гүйцэтгэх үндсэн ажил тул эдгээр ХАБЭА-н ажилтнуудад энэхүү аргачлал үнэ цэнэтэй гарын авлага болно гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Хөдөлмөрийн дэд сайд, ХАБЭА-н үндэсний хорооны дарга
Ж.Батхуяг

Эрхэм хүндэт ноёд, хатагтай нараа, Монгол Улсын уул уурхайн салбарт ажиллагсдаа,

энэхүү “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог нэвтрүүлэх аргачлал” хэвлэмэл гарын авлагыг Та бүхэнд танилцуулж байгаад таатай байна.

Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Эрчим Хүчний Яамнаас санхүүжүүлдэг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөр нь Монгол Улсын зөвхөн уул уурхайн салбарт бус, бусад компаниуд ч гэсэн ашиглах боломжтой хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) зааварчилгаа боловсруулах даалгавар хүлээж авсан билээ. Энэхүү ажлын хүрээнд “Монголын Алт” корпорацитай хамтарч, Германы тус салбарын мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр ХАБЭА-н удирдлагын аргачлалыг танилцуулж, германы, европын болон олон улсын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн стандартад дүн шинжилгээ хийсэн болно.

Эл хамтын ажиллагааны үр дүнд ажил олгогчид, ХАБЭА-н менежерүүд болон ажилчдад зарим хөдөлмөрийн аюул занал ажлын байранд ямар сөрөг нөлөө үзүүлдэг, түүнчлэн осол ба гэнэтийн аюулын байдалд ямар арга хэмжээ авах тухай зааварчилгаа бүхий гарын авлагыг бэлтгэсэн юм. Энэхүү гарын авлага нь уул уурхай, хортой бодистой үйл ажиллагаа явуулдаг эсхүл өвчлөл, гэмтлээс хамгаалсан хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журмын дагуу ажилладаг аюултай ажлын байр бүхий компаниудад дэмжлэгэ болох зорилготой. Компаниуд осол гэмтлийн үр дагавар тэдгээрийн санхүүгийн гүйцэтгэлд хэрхэн нөлөөлхийг ойлговоос чадварлаг хүний нөөцөө тогтоохын тулд ажилчдын хөдөлмөрийн эрүүл ахуйг баталгаатай байлгахын тулд улам их идэвхи, санаачилгатай хөтөлбөр хэрэгжүүлэх болно.

ГОУХАН ЭТИС хөтөлбөрийн захирал Др. Штефан Ханселманн

Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци нь төр, хувийн хэвшлийн 190 гаруй аж ахуйн нэгж, байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн, тэдний хууль ёсны эрх ашиг, сонирхлыг төлөөлөн, тэдний дуу хоолойг Монгол Улсын уул уурхайн салбар дахь төрийн бодлогод тусгуулахыг чармайн, салбарын талаарх үнэн бодит мэдлэгийг нийгэмд түгээж, гишүүддээ чиглэсэн үр нөлөөтэй үйлчилгээ үзүүлж, улмаар нийгмийн хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахын төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага юм.

Бид хариуцлагатай уул уурхайг Монгол Улсын эрдэс баялгийн салбарын аливаа үйл ажиллагааны тулгуур зарчим болгон хэвшүүлж, хөгжүүлэх зорилт тавин ажилладаг. Энэ хүрээнд тус салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог хэвшүүлэх чиглэлээр багагүй ажил зохион байгууллаа. Тухайлбал, уул уурхайн үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангахад тулгарч буй эрсдэл, хүндрэл бэрхшээл, тэдгээрийг даван туулах боломжийг хамтдаа хайх, бие биенийхээ тэргүүн туршлагаас суралцах боломжийг нээх үүднээс 2012 оноос “Нэн түрүүнд хөдөлмөрийн аюулгүй байдал” бага хурал, үзэсгэлэнг жил бүр зохион байгуулж байна. Уг арга хэмжээний томоохон үр дүн нь “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо MNS OHSAS 18001:2012” стандартыг батлуулсан явдал юм.

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, менежментгүйгээр уул уурхайн үйлдвэрлэл дэх осол эндэгдлийг багасгах, бууруулах аргагүй. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдлийг урьдчилан тооцоолж, түүний хор хохирлыг бууруулах удирдлага менежментийн цогц төлөвлөгөө, арга механизм, түүнийг ягштал биелүүлэх ухамсар дадал, зан төлвийг салбарын аж ахуйн нэгжүүддээ хэвшүүлэх, MNS OHSAS 18001:2012 стандартыг сурталчлан таниулах чиглэлээр бид ихээхэн анхаарч ажиллах болно.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог нэвтрүүлэх аргачлал (OHSAS 18001) гарын авлагыг боловсруулсан Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялгийн түүхий эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөр, “CBM” зөвлөх компанийн хамт олны ажил үйлсэд өндөр амжилт, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ Д.ДАМБА



Эрхэм хүндэт ноёд хатагтай нараа,
“СиБиМ” ХХК нь германы зөвлөх байгууллага бөгөөд дараахи
чиглэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон байгаль хамгаалал
- Хувь хүний болон компанийн хөгжил
- Олон улсын уул уурхайн компаниуд.

Бидний үйл ажиллагааны үндсэн сэдвийн нэг бол удирдлагын тогтолцоог хэрхэн бий болгох, түүнийг хэрэгжүүлэх асуудал юм. “СВМ” компани үндэсний болон олон улсын түвшинд гүйцэтгэсэн төслүүдээс олж авсан туршлагадаа тулгуурлан олон жилийн туршид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд (ХАБЭА) чиглэсэн ажлын чанар болон бүтээмжийг дээшлүүлэх бодлого зөвлөгөөний аргачлалыг боловсруулсан байна.

Тус гарын авлага нь хоёр талын хамтын ажиллагааны үр дүн бөгөөд Монгол улсын уул уурхайн салбарт сүүлийн үеийн, олон улсын стандартын дагуу боловсруулсан ХАБЭА-н удирдлагын тогтолцоог суурьшуулан дэмжих зорилготой.

Бид та бүхэнд Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийн сайн сайхны төлөө чиглэсэн ХАБЭА-н сэдвийг шинэ түвшинд гаргаж ирэхийг хүсэн ерөөж байна.

Др. Томас Траппе, “СиБиМ” ХХК

Гарчиг

1	Удиртгал	7
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо	12
2.1	Компанийн ХАБЭА-н удирдлагын тогтолцоог хөгжүүлэх	12
2.2	ХАБЭА-н удирдлагын тогтолцооны үүрэг	13
3	ХАБЭА-н удирдлагын тогтолцооны бүтэц зохион байгуулалт	14
3.1	Компанийн хэтийн бодлого, зорилго	14
3.2	Зохион байгуулалт, төлөвлөлт	16
3.2.1	Оролцоо / ХАБЭА-н удирдлагын тогтолцооны бүтэц, зохион байгуулалт	16
3.2.2	Компани ХАБЭА-н удирдлагын тогтолцоогоо хянах нь	18
3.2.3	Эхний суурь тулгын чулуу → ХАБЭА-н удирдлагын тогтолцоог бий болгох	19
3.2.4	Компанийн удирдлага, хариуцлага	21
3.2.5	Эрх зүйн болон бусад тавигдах шаардлагууд	21
3.2.6	Зохион байгуулалт, хариуцан тайлагнах, оролцоо, үүрэг хариуцлага, эрх мэдэл	21
3.2.7	ХАБЭА-н удирдлагын тогтолцооны төлөвлөлт, зорилго, зорилт	21
3.2.8	Аюул, эрсдлийн шинжилгээ	22
3.2.9	Хохирлыг бууруулах, арга хэмжээний дэс дараалал	24
3.2.10	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	26
3.2.11	Ажлын байрны эрүүл мэнд	26
3.2.12	Гэмтэл ослыг мэдэгдэх, бүртгэх, арга хэмжээ авах	28
3.2.13	Тоног төхөөрөмж, машин механизм, үйлдвэрийн болон хөдөлмөрийн хэрэгсэл	31
3.2.14	Хортой болон аюултай бодисын удирдлага	32
3.2.15	Гэрээт байгууллагууд, нийлүүлэгчид, түнш болон зочид	33
3.2.16	Баримт бичгийн шалгалт, мэдээллийн удирдлага	33
3.2.17	Гэнэтийн ослоос хамгаалах, төлөвлөх	34
3.2.18	Хоёрдох тулгын чулуу - нөхцөл байдлын дүн шинжилгээ	36
3.2.19	Гурав дахь тулгын чулуу - байх ёстой ба байгаа байдлын дүн шинжилгээний харьцуулалт	37
3.3	Хэрэгжилт	39
3.3.1	Удирдлага ба ажилчдын нэгдмэл байдал	39
3.3.2	Үйл ажиллагааны явцтай уялдуулах, удирдан зохион байгуулах	40



германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Implemented by:

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага хөтөлбөр
Integrated Mineral Resource Initiative

3.3.3	Бүтэц зохион байгуулалттай уялдуулах	41
3.3.4	Харилцаа холбоо, хамтын ажиллагаа	42
3.4	Хэрэгжилтийн хэмжүүр	45
3.5	Хэрэгжилтийг үнэлэх	47
3.6	Аудит / хөндлөнгийн хяналт	48
4	Хураангуй	49
5	Холбоо барих	51
6	Нэр томъёоны тайлбар	53
7	Зураг зүй	59

1 Удиртгал

Монгол улс газар доорхи эрдэс түүхий эдийн нөөц баялгаараа баян улс орнуудын тоонд ордог бөгөөд 1990 оноос эхлэн өөрийн бие даасан уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлж байна. Тус улс нь төр болон хувийн хэвшлийн салбарт өрсөлдөх чадвараа сайжруулахын тулд хөгжлийн гараан дээрээ зогсож буй уул уурхайн салбарт европын болон олон улсын техник, байгаль орчин болон ХАБЭА-н стандарт, хэм хэмжээг хэрэгжүүлэх ажилд нэгдэн орсон байна. Монгол Улсын Засгийн газар нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас (ОУХБ) гаргасан олон улсын стандартыг дагаж мөрдөж байгаа билээ.

Эдийн засаг, нийгэм болон байгаль хамгааллын ижил тэгш байдлыг хангаж ажиллах нь дэлхийн хэмжээнд бүх л аж ахуйн нэгжийн томоохон даалгавар болоод байгаа билээ. Үүнээс улбаалан аж үйлдвэрүүд өндөр зохион байгуулалттай, нарийвчлагдан судлагдсан иж бүрдэл тогтолцоог аль болох ашигтайгаар үйлдвэрлэлд нэвтрүүлэхийн тулд зорин ажиллаж байна. Энэхүү удирдлагын тогтолцооны аргачлалын хүрээнд тухайн байгууллагын стратегийн зүг чиг, компанийн бүтэц зохион байгуулалт, үйл явц, үйл ажиллагааны түвшинд хэтийн төлөвлөгөө, төлөвлөлт, удирдлага, хэрэгжүүлэлт ба тасралтгүй сайжруулалт зэргийг хамруулдаг.

Энэхүү хандлага нь ХАБЭА-н сэдэвт хамрагдах орчин үеийн аж ахуйн нэгжийн хөдөлмөр болон эрүүл ахуйд хамааралтай. ХАБЭА-н удирдлагын тогтолцоо нь байгууллагын хувьд ихээхэн үр ашиг бүхий хөдөлмөр хамгааллын аргачлалыг бий болгож байгаа бөгөөд түүний тусламжтайгаар ажлын байрны аюулгүй ажиллагаа сайжирч улмаар ажилтан, ажиллагсдын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах аж. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн тогтолцоо нь тухайн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлын зорилтод тулгуурлан системтэйгээр төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэн хянаж, тасралтгүй сайжруулахад оршино. ХАБЭА нь үйлдвэрийн бүх ажиллагсдыг хөдөлмөр хамгаалалтын үйл ажиллагаанд идэвхитэй оролцохыг уриалах хэрэгтэй юм. Улмаар ажиллагсад, зочид, ханган нийлүүлэгчид болон гэрээт компаниудын аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг зохицуулж, олон нийт болон байгаль орчныг эрсдэлд оруулахаас сэрэмжлэх зорилготой билээ.



Зураг 1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын давуу талууд


Компанийн үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хоёрыг нэгтгэснээр компанийн эдийн засгийн бүх л үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлээд зогсохгүй эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхийн сацуу үйлдвэрийн аюулгүй байдлыг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй. Энэхүү хөдөлмөр хамгааллыг системтэйгээр ашиглах нь осол, өвчлөлөөс үүдэх үйл ажиллагааны доголдлыг бууруулж мөн ажилчдын хөдөлмөрийн бүтээмжийг аюулгүй байдлын өөрийн ухамсар оролцоогоор дээшлүүлэх гэх мэт ил тод үр дүнгээр тодорхойлж болно.

Үүний тулд олон улсын стандартууд болон хэрэгцээ шаардлагууд нь гадны оролцогч талууд буюу Stakeholder (үйлчлүүлэгчид, хөрөнгө оруулагчид эсвэл дэмжих байгууллагууд) болон төрийн байгууллагуудаар (хуулийн дүрэм журам дагаж мөрдөх) дамжиж энгийн бөгөөд оновчтой хэрэгжиж биелэх юм. ХАБЭА-н тогтолцоог нэвтрүүлснээр ажил олгогч нь Монгол Улсын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-д (хуулийн 27-р зүйл) тусгагдсан үүргийн дагуу ХАБЭА-г зохих ёсны дагуу зохион байгуулах шаардлагатай. Энэ бүгдээс үүдэлтэй өсөн нэмэгдсэн компанийн нэр хүнд, имидж нь өрсөлдөх чадварын давуу тал, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд болон ажилчдын сэтгэл хангалуун байдлыг бэхжүүлэн батжуулахад таатай нөлөө үзүүлдэг.

ХАБЭА нь дараах зүйлүүдэд нөлөөлнө:

- үйлдвэрийн үйл явц оновчтой болно
- удаан хугацаанд ажиллагсдыг тогтоох/ шилжилт хөдөлгөөний багасгах
- компанийн эрсдэл буурна
- доголдолгүй үйлдвэрлэл
- эд материалын хохирлын тоо багасна
- цагийн алдагдлыг бууруулна
- ажилчдын чадвар дээшилнэ

Өөрийн өрсөлдөх чадвараа дээшлүүлнэ гэдэг аливаа компанийн чухал зорилго юм. Үүнд компанийн доторх олон талт харилцан үйлчлэлцэх хүчин зүйлүүд хоорондоо уялдаа холбоотой байдаг. Эдгээр нь компанийн эзэн, удирдлага, ажилчид болон үйл ажиллагаа юм. Энэ системд дотоод шаардлагаас гадна, гадаад төрөл бүрийн хүчин зүйлүүд мөн адил нөлөөлдөг. Тухайлбал, үйлчлүүлэгчид, хөрөнгө оруулагчид болон төр засаг гэх мэт.



Зураг 2: Компанийн харилцагч талууд

Энэ мэтчилэн өсөн нэмэгдэж буй шаардлагуудыг ханган гүйцэлдүүлэхийн тулд дэлхийн олон улс орон компанийхаа дотоод үйл ажиллагаанд “Сайн туршлага”-аар сайжруулсан үйл ажиллагааны цогц менежментийн тогтолцоог

нэвтрүүлсэн байдаг. Тус менежментийн тогтолцоо нь орчин үеийн компанийн удирдлагын зайлшгүй шаардлагатай салшгүй нэг хэсэг болж өгдөг бөгөөд үүний хажуугаар зах зээл, үйлчлүүлэгч, төр болон харилцагчдын шаардлагуудад чиглэсэн компани дахь зохион байгуулалтыг оновчтой болгоход чухал нөлөөтэй.

Нэгдсэн удирдлагын тогтолцоо нь чанарын баталгаажуулалт, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрчим хүчний удирдлага зэрэг олон салбарын хэрэгцээ шаардлагуудыг хангаж байх арга хэрэгслүүдийг нэгтгэн нэг бүтэцэд багтаадаг. Нормчлогдсон удирдлагын системүүд өөр хоорондоо бүтцээрээ адилхан учраас (гарын авлага, ажлын зохион байгуулалт г.м.) тэдгээрийг нөөцтэй холбож, харилцан үйлчлэлийг олон салбарын сайжруулалтад давхар зорьж болно. Нэгэнтээ бүрэлдэж бий болсон удирдлагын тогтолцоог бусад салбарт шинээр нэгтгэхийн тулд харьцуулж буй бүтцүүдийн тусламжтайгаар хялбар аргаар өргөтгөх боломжтой. Мөн бүхий л ISO-гийн норм хэмжээнд тогтмол шаардагддаг өөрийн хяналт шалгалтыг (аудит, удирдлагын хяналт г.м.) бага хэмжээний нөөцөөр гүйцэтгэж болох юм.

Цогц удирдлагын тогтолцоо				
Байгаль орчны удирдлагын тогтолцоо	ХАБЭА-н удирдлагын тогтолцоо	Эрчим хүчний удирдлагын тогтолцоо	Эрсдэлийн удирдлагын тогтолцоо	
/ж/нь ISO 14001/	/ж/нь OHSAS 18001/	/ж/нь ISO 50001/	/ж/нь ISO 31000/	
		Чанарын удирдлагын тогтолцоо /ж/нь ISO 9001/		

Зураг 3: Цогц удирдлагын тогтолцоо

Энэхүү гарын авлагад бичсэн хөдөлмөр хамгааллын үзэл баримтлал нь үйл ажиллагаандаа хөдөлмөрийн аюулгүй байдлын чухал нэгжүүдийг нэвтрүүлсэн тухайн компаниудад “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын үр ашигтай систем”-ийг бий болгох үндэс суурийг тавьж өгөхөд чиглэгдсэн болно. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон эдийн засгийн үр ашгийн зорилгуудад хүрэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд OHSAS 18001, ISO 9001, 140001 зэрэг олон улсын удирдлагын тогтолцоо буюу стандартуудын уялдаа холбоог тусгасан байдаг.


2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо

2.1 Компанийн ХАБЭА-н удирдлагын тогтолцоог хөгжүүлэх

Аливаа компанийн шийдвэр гаргагч түвшний удирдлага нь үйлдвэрийг хөгжүүлэх алсын харааг тодорхойлохын тулд бизнес, стратегийн төлөвлөгөөг

гаргадаг билээ. Энэ нь тухайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хүний нөөц, багаж хэрэгсэл, санхүү болон хөрөнгө оруулалт зэргийг тодорхойлдог байна. Ингэснээр тухайн үйлдвэрийн анхны нөхцөл байдлыг дүрслэн гаргадаг байна.

Үүн дээр тулгуурлаж тухайн компанийн ХАБЭА-н бодлогыг зорилтын хамт боловсруулна. Дараагийн алхамд ХАБЭА-н нэгж хэлтсийг байгууллагын дотор үүсгэж, зохих стандартууд болон багаж хэрэгслийг тогтоож системийг нэвтрүүлэх явцыг зохион байгуулах бичиг баримтыг үйлдэнэ. Энэхүү ажилд удирдах албан тушаалтан, ажиллагсдыг хамруулна. Үүний дараагаар байгууллагын ажлын явцад нэгтгэх ажил эхлэх бөгөөд бүх ажилтан албан хаагчдыг сургалт семинарт оролцуулж эхэлнэ. ХАБЭА-н амжилт нь тухайн үйлдвэрийн тавьсан зорилтуудын биелэлт болон зарим тоо баримтаар илрэх бөгөөд түүнийг хэмжиж, үнэлж дахин сайжруулах зүйл байгаа эсэхийг тогтмол шалгах шаардлагатай.



Зураг 4: ХАБЭА-н зураглал

2.2 ХАБЭА-н удирдлагын тогтолцооны үүрэг

ХАБЭА-н удирдлагын тогтолцооны амжилт нь байгууллагын удирдлага өөрөө хэрхэн чанд сайн дагаж мөрдөж буйгаар тодорхойлогдоно. Үүний хажуугаар тухайн аж ахуйн нэгжийн гишүүн бүр тодорхой ойлголттой байх ба хүн бүр дор

бүрнээ хариуцлага хүлээж байж систем зөв ажиллахыг ухамсарласан байх нь чухал юм. Үүнд үйлдвэрийн удирдлага, менежер, ажилчид, аюулгүй байдлын хэлтсийнхэн, гэрээт компани болон зочдын үүрэг хариуцлагыг маш тодорхой зааж тодорхойлж өгсөн байх ёстой.

Ажиллагсад чиглэгдсэн дүрэм, эрх үүрэг, арга замыг компанийн даяр удаан хугацаанд баримтлах чухал юм. Үүгээр менежментийн тогтолцоо нь удирдлагын үзэл баримтлал өөрчлөгдөхгүйгээр гол үйл ажиллагаанд туслагч процес болох мөн ингэснээр үйл ажиллагааг тогтмол сайжруулахад дэмжлэг үзүүлэх аж.

ХАБЭА-н удирдлагын тогтолцооны зорилго:

- Үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг дэс дараалалтайгаар зохион байгуулах, нутагшуулах
- Хөдөлмөр хамгааллыг удирдлагын үүргийн түвшинд авч хэрэгжүүлэх
- Хөдөлмөр хамгаалалын асуудлыг сайжруулахад нийт ажилчдын оролцоог нэмэгдүүлэх
- Ажиллагсдын болоод эд материал, үйлдвэрийн бүсэд байгаа хүмүүсийн болон үйл ажиллагааны хүрээнд байгаль орчинд учирч болзошгүй аюул осол, эрсдэл ачааллыг танин мэдэж дүн шинжилгээ хийх
- Мэдэгдэж байгаа аюул эрсдлийг хамгаалалтын арга хэмжээний тусламжтайгаар зайлуулах болон бууруулах
- Бүх төрлийн доголдлыг дэс дараатайгаар арилгах
- ХАБЭА-н удирдлагын тогтолцооны хэрэгцээ шаардлагууд, хууль тогтоомж, төр засгийн болоод өөрсдийн хэм хэмжээнд нийцэх эсэхийг баталгаажуулах
- Найдвартай ажиллагаатай хяналтын тогтолцоог бий болгох
- Компанийн доторх ХАБЭА-г тогтмол сайжруулах

ХАБЭА-н удирдлын тогтолцоог нэвтрүүлснээр ажиллагсдын осол, өвчлөлөөс үүдэлтэй цаг хугацааны алдагдал буурч, эд материалын хүрэлцээ хүртээмж дээшилж мөн улмаар үйлдвэрлэлийн болоод үйл ажиллагааны саатал багасдаг. Ингэснээр компанийн эдийн засаг бэхжих давуу талтай.

3 ХАБЭА-н удирдлагын тогтолцооны бүтэц зохион байгуулалт

3.1 Компанийн хэтийн бодлого, зорилго

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй нь байгаль хамгаалал, хүрээлэн буй орчин, чанарын баталгаажуулалт мөн компанийн нийгмийн хариуцлага шиг компани дахь нэмүү өртөг бий болгох болон үнэ цэнийг сайжруулах гол үйл явцын төв туслах үйл явцын нэгийг тодорхойлдог. Энэ асуудлыг компанийн

хэтийн бодлоготой холбох нь байнга тохиолддог ба мөн боломжийн харилцан ашигтай байхаар чиглэсэн байна.

Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйтай холбоотой компанийн үндсэн суурь сэдэл, санаа болон зохицуулалт нь компанийн дээд удирдлагаар (үндсэн зарчмийн тайлбар) бичгээр баримтжуулагдана.

Тухайн бодлого нь зорилго, үйл ажиллагааг илтгэх ба тодорхой үндсэнд суурилсан компанийн хэтийн төлөв байдлийг тодорхойлдог. Компанийн хэтийн бодлогыг тодорхойлох явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсэн удирдамжуудыг бий болгож болно. Эдгээр удирдамжуудад тэдгээрийн гол санаануудыг компанийн хэтийн бодлогоос оруулж, энгийн ойлгомжтой үгээр тайлбарлаж өгвөөс зохистой.

Үйл ажиллагаа нь тогтворжсон ХАБЭА-н тогтолцоо нь компанийн дээд удирдлагад компанийхаа ХАБЭА-н үндсэн чиг, бодлогыг хэрэгжүүлэхэд дэм болдог. ХАБЭА-н системийн зорилго, хэрэгцээ шаардлагуудыг тодорхойлохдоо хүн болоод байгалийн эрүүл ахуй, аюулгүй байдалд ямар хүчин зүйл, нөхцөлүүд занал хийж буйг анхаарч үзэх шаардлагатай. Үүний хажуугаар ХАБЭА-н системийн ямар бодлого хэрэгжүүлж, хэрхэн эрсдлийг тойрч гарах, ХАБЭА-н тогтолцоог хэрэгжүүлсэнээр юунд хүрч болох болоод хэрхэн үйлдвэр дэх хөдөлмөр хамгааллыг удирдан зохион байгуулах вэ гэдгийг давхар бодолцох хэрэгтэй.

ХАБЭА-н удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх явц юуны өмнө стратегийн бизнес төлөвлөгөө боловсруулахаас эхэлнэ. Үйл ажиллагааны стратегийн төлөвлөлтөд компанийн дотоод шаардлагуудын эхний хэсгүүдийг тодорхойлно. Үүнд хөдөлмөр хамгааллын үндсэн зорилгууд бас орно. Түүнчлэн “компанийн ямар салбар, хэдий хугацаанд хэрхэн зохион байгуулагдах, ямар бүтэцтэй байх вэ?”, “дээд удирдлагын ямар гишүүн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйнхаа үндсэн чиг зорилгын бодит биелэлтэд нэн түрүүнд хариуцлага хүлээх вэ?” гэх мэт асуудлыг тодруулах хэрэгтэй.

Тухайн зорилтыг дэвшүүлэхэд түүний шалгаан болон суурь нөхцөл байдлыг тэмдэглэж явах нь хожим зорилгыг үнэлэхэд чухал байдаг. ХАБЭА-н зорилтууд компани даяар адилхан эсхүл зөвхөн тодорхой хэсэгт зориулагдсан онцгой зорилт байж болно. Энэхүү зорилтууд болон зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг холбогдох бүх хүмүүст хүргэж мэдэгдэнэ.

Тухайн захиалагч байгууллагын үйл ажиллагааны чиглэл, ажиллагсадын тоо болон нэвтрүүлэхийг зорьсон системийн хэрэглэгдэх байдлаас шалтгаалан хөдөлмөрийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хамрах цар хүрээ, нарийвчлалын хэмжээ болон түүнд зарцуулах үйлчилгээний хэм хэмжээ ялгаатай байдаг.

Зорьж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүтээмжийг тодорхойлоход тэдгээрийн биелэх магадлалд тавих хөндлөнгийн шалгалтгүйгээр тооцоолох боломжгүй юм. Ингэснээр тохиолдож болох хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зорилтыг хэт дөвийлгөж, биелүүлэх боломжгүй зорилтууд дэвшүүлхээс урьдчилан сэргийлэх аж. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагын дагуу биелүүлэх ёстой зүйлүүдийн тоо хэт их байснаас болж ажилчдын дунд үл ойшоох явдал гардаг. Тийм учраас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого амжилттай хэрэгжихэд гол нөлөөлөх зүйл бол ажилчид түүнийг хүлээн зөвшөөрөх явдал юм. Энэ утгаараа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг компанийн дээд удирдлага болон бусад шатны удирдлагууд өөрсдөө хариуцлагатайгаар дагаж мөрдөх нь бусад ажилчдад үлгэр дуурайлал болох учиртай юм.

3.2 Зохион байгуулалт, төлөвлөлт


3.2.1 Оролцоо / ХАБЭА-н удирдлагын тогтолцооны бүтэц, зохион байгуулалт

Үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үр нөлөө болон үр ашгийн дийлэнх хэсэгт нийт ажилчдын оролцоо томоохон үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс дээд удирдлагын бүх шатанд хөдөлмөрийн аюулгүй байдлын удирдлагын системийн талаарх шийдвэрээ уламжилж байх болон хүн бүр дор бүрнээ амжилтанд хүрэхийн тулд чармайж байх нь чухал юм. Энэ нь үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нь компанийн соёлын нэгээхэн хэсэг болж суурьшихад чухал нөлөөтэй юм.

Ерөнхийдөө хариуцлага гэдэг нь дараах утгыг агуулдаг: Хариуцлага = Эрх + Үүрэг

Удирдах алба болон ХАБЭА-н тогтолцоонд хүлээх үүрэг хариуцлагууд:


- Зохион байгуулалтын хариуцлага
- Удирдлагын хариуцлага
- Сонгох хариуцлага
- Хяналт шалгалтын хариуцлага



Зураг 5: Удирдах албан тушаалтын хариуцлага хүлээх байдал

Ажилчид болон үйлдвэрийн гаднах этгээд ч гэсэн өөрийн хариуцлагын хүрээнд дараах эрх үүргийг давхар хүлээдэг:

- Байрлуулах эрх үүрэг (боломжтой)
- Мэдэгдэх эрх үүрэг
- Хамтрах оролцох эрх үүрэг
- Туслан дэмжих эрх үүрэг



Зураг 6: (алтан судал) голлох үйл явцын үнэлгээнд ХАБЭА-ны нөлөөлөл.


ХАБЭА-н тогтолцоо нь компанийн бүхий л үйл ажиллагаа болоод үйл явц арга ажиллагаанд зурган дээр харуулсан алтан утас мэт оролцдог, тиймээс төвийн зарчмаар зохион байгуулагдах ёстой. Энэ үйл ажиллагааг компанийн хөдөлмөр хамгааллын хэлтэс хариуцдаг. Эл хэлтэс нь ХАБЭА-н тогтолцоог нэвтрүүлэх үүрэг давхар оногддог. Ингэхдээ компанийн бусад хэлтэсүүдийн (үйлдвэрлэл, судалгаа, санхүү болон хуулийн хэлтэс г.м.) шийдвэр, арга хэмжээ мөн гишүүдийнх нь нөлөөллийг харгалзах үзэх шаардлагатай. Энэ мэтээр тулгарч буй асуудлыг мэргэшсэн мэргэжилтнүүдийнхээ (Cross-Functional Team = CFT) тал бүрийн ур чадвар, чадавхи болоод мэдлэг, туршлагаар зардал багатайгаар шийдэж болно.

Үүнээс гадна төлөвлөлтийн явцад явагдаж буй хамтын ажиллагаагаар харилцан ойлголцол болоод асуудлыг хүлээн зөвшөөрөх хандлага дээшлэхэд нөлөөтэй. Өөрсдийн мэргэшсэн мэргэжилтнүүдийг орлуулая гэвэл гадны мэргэжилтнүүдийг (аюулгүй ажиллагааны мэргэжилтэнг) CFT-дээ нэгтгэхийг санал болгодог. Компанийг гаднаас харж байгаа ажигласан байдал мөн тэдний мэргэшсэн чадвар туршлага нь компанийн алдаа дутагдал болоод шаардлагагүй зардлыг арилгах зорилгтой юм.

Төслийг төлөвлөхөөс эхлээд хэрэгжүүлэх бүхий л шатанд хөндлөнгийн шалгалтын багийн бүх гишүүдийн хооронд үл ойлголцох байдал үүсгэхгүй байхын тулд зарим нэг мэргэжлийн ухагдахуун болон товчилсон үгсийн жагсаалтыг урьчилан ярилцаж тогтсон байх нь нэгэн чухал алхам байна. Иймд энэхүү гарын авлагад үг хэллэгийг тайлбарласан товч тайлбар толь оруулсан болно.

3.2.2 Компани ХАБЭА-н удирдлагын тогтолцоогоо хянах нь

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажиллагааны хамгаалалтын зорилтуудыг хэрэгжүүлэхийн өмнө компанийн нарийвчилсан хөндлөнгийн шалгалтыг хийлгэх нь хөдөлмөрийн аюулгүй байдлын удирдлагын системийг нэвтрүүлэхэд чухал алхам болдог. Компанийн хөндлөнгийн шалгалт нь гурван үндсэн хэсгээс бүрдэнэ:



Зураг 7: Хяналт.

Зорилтоо тодорхойлж, засварлан → хэрэгжүүл

Задлан шинжилгээ хийж → төлөвлө

Одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж → ажилла

Хүрэх ёстой-байгаа нөхцөл байдлын харьцуулалт хийж → хяна

3.2.3 Эхний суурь тулгын чулуу → ХАБЭА-н удирдлагын тогтолцоог бий болгох

Эхний ээлжинд хөдөлмөрийн аюулгүй байдлын чухал нэгжүүдийн байгууллагад байвал зохих тоо хэмжээг үнэлгээ хийж гаргана. Аливаа байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хариуцсан нэгжүүдийн тоо болон хэмжээ нь тухайн байгууллагын үйл ажиллагааны хэлбэр болон ажиллагсадын тооноос хамаардаг.

Энэ нь дотоодын бүлгүүдийн шаардлага ба гадны хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдын сонирхол гэсэн хоёр хэсэгт хуваагддаг. Аливаа хууль, эрх зүйн байдал нь тухайн үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байх ёстой хэм хэмжээг тодорхойлж байдаг. Тийм учраас хуулийг даган мөрдөх биелүүлэх нь хамгийн чухал юм. Үүний дараагаар гадны хөрөнгө оруулагчид

болон хувьцаа эзэмшигчдийн сонирхол ордог. Жишээлбэл: банк, үйлчлүүлэгчид, итгэмжлэгч байгууллагууд мөн нийгмийн сонирхол (КНХ) гэх мэт.

Байгууллагын зорилго болон зорилтоос байгууллагын дотоод үзэл баримтлал нь тодорхойлогдох бөгөөд дотоод болон гадаад сонирхлын бүлгийн эрх ашгийг хангаж байхаар боловсруулна.

“Сайн туршлага” –г хангасан олон улсын хөдөлмөрийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ерөнхий бүтцийг доорхи зурагт үзүүлсэн болно.



Зураг 8: ХАБЭА-н удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд

Аливаа аж ахуйн нэгж нь хөдөлмөрийн аюулгүй байдлын нэгжийг бий болгож ажиллуулснаар байгаа болон байвал зохих хүчин зүйлсийн дүн шинжилгээний өгөгдөл болоод зогсохгүй ажлын талбар дахь ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг сайжруулж улмаар компанийн нэр хүндийг дээшлүүлнэ.

Аж ахуйн нэгж, байгууллага бүр өөрийн хэмжээнд тохирсон ХАБЭА-н нэгжүүдийг тухайн байгууллагын хэмжээнд үйлчилж байгаа ХАБЭА-н стандартуудын хүрээнд баримтжуулж мөн хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүний дараагаар тухайн нэгж бүрийн ажлын хамрах хүрээ болон ажлын тодорхойлолтыг гаргаж улмаар ХАБЭА-н зааварчилгаа болон ажлын багаж хэрэгслүүдийг нийлүүлэх ажлыг компанийн хэмжээнд хийж гүйцэтгэнэ.

3.2.4 Компанийн удирдлагын үүрэг, хариуцлага

Аливаа компаний удирдах албан тушаалтан нь зөвхөн удирдахаас гадна хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий зорилго, хэм хэмжээг тодорхойлох үүрэгтэй. Улмаар гаргасан дүрэм журмыг өөрийн байгууллага даяар хэрэгжүүлж, биелүүлж ажиллахад санаа тавьж, мөн доод түвшний ахлах ажилтнуудаас ХАБЭА-н өдөр тутмын үйл ажиллагааг хангаж ажиллаж байгаа эсэхт хяналт шаардлага тавьж ажиллана. Түүний эрхэм зорилго нь ХАБЭА-н тогтолцооны бүтэц зохион байгуулалтын хяналт хамгаалалт, тогтмол сайжруулалтыг хэрэгжүүлэхэд оршино. Удирдлагын хувийн санаачлагатай болон цаг тогтмол оролцоо нь ХАБЭА-н системийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, шийдвэрлэхэд нөлөө үзүүлнэ. Түүнчлэн үйлдвэрийн ажилчид болон ХАБЭА-н мэргэжилтнүүдийн хоорондын болон гэрээт компанитай харилцан мэдээлэл солилцсон уян хатан харилцааны хэлбэр нь чухал юм.

3.2.5 Эрх зүйн болон бусад тавигдах шаардлагууд

Аливаа ХАБЭА нь хуулийн болон үйлдвэрлэлийн нэгдсэн заалтуудыг харгалзаж үздэг. Үйлдвэрийн дотоод аюулгүй ажиллагааны дүрэм журмыг дагаж мөрдөхийн зорилго нь ирээдүйгээ харсан тогтвортой ажлын байрыг бий болгоход оршино. Энэхүү дүрэм журамд тогтмол хяналт шалгалт хийж, байнга шинэчилж байх хэрэгтэй. Дотооддоо хэрхэн ХАБЭА-н хүрээнд харилцахыг дээд шатны удирдлага тогтоож чиглэлийг боловсруулна.

3.2.6 Зохион байгуулалт, хариуцан тайлагнах, оролцоо, үүрэг хариуцлага, эрх мэдэл

Байгууллагын бүх түвшинд энгийн ажилтнаас эхлээд хамгийн дээд захирал цаашилбал гэрээт ажилтны ХАБЭА-тай холбоотой бүхий л эрх үүрэг, хариуцлагын тухай маш ойлгомжтой тодорхойлж, бичгээр үйлдэн боловсруулсан байна. Үүнийг байгууллагын зурагласан бүтцээс олж харах боломжтой байх ёстой.

3.2.7 ХАБЭА-н удирдлагын тогтолцооны төлөвлөлт, зорилго, зорилт


ХАБЭА-н хэмжиж болох зорилтуудыг юуны өмнө тогтоох шаардлагатай. Компанийн хөндлөнгийн шалгалт дүгнэлт, ХАБЭА-н хэтийн бодлогын баримтлал болон бусад шалгалтын үр дүнг харгалзан хөдөлмөр хамгаалалын чиглэлд баримтлах үзэл баримтлал гаргаж болох бөгөөд уг баримтлал нь үндэсний хууль эрх зүйн орчинд нийцсэн, үнэн бодит байдалд ойрхон, биелүүлж болохуйц гэсэн нөхцлүүдийг хангаж байх ба тодорхой хугацаанд түүнийг шалгаж, үнэлж, шинэчилж байх нь зүйтэй. Тухайн үзэл баримтлалын ерөнхий зорилго нь аливаа ажилтны эрүүл мэнд болон ажиллах орчныг тогтмол сайжруулж, улмаар илүү их бүтээмжийг бий болгоход чиглэдэг.



3.2.8 Аюул, эрсдлийн шинжилгээ

Тухайн ажлын байрны тодорхойлолт, эрсдлийн үнэлгээ нь ихээхэн чухал бичиг баримт бөгөөд түүний тусламжтайгаар ХАБЭА-н мэргэжилтэн нь ажлын байранд үүсэх эрсдэл, түүнтэй хэрхэн тэмцэх, ослыг арилгах зэрэг даалгаварыг гүйцэтгэнэ.

Хялбарчлан авч үзвээс аюулгүй байдлын ажлын нөхцөл бүрдсэн бүтээмж өндөртэй ажлын байранд эрүүл бөгөөд аюулгүй ажиллагааг ухамсласан ажилтан ажиллуулахыг аливаа компани зорилгоо болгодог билээ. Үүний тулд тухайн байгууллагын осол гэмтлийн тоо ил тод, эрсдлийг урьдчилан олж илрүүлсэн байх хэрэгтэй. Аливаа осол эндэгдэл гарах магадлал, үүсэж болон хохирлын хэмжээнд тулгуурлаж эрсдлийн таамаглалыг боловсруулдаг.



Зураг 10: Эрсдлийн үнэлгээ

Аливаа ажлын байранд үүсэж болох аюул ослыг тооцоолж, тохиолдох боломжыг тооцоолон таамагласны тусламжтайгаар үүсэх хохирлоос сэргийлж, багасгах боломжтой. Ажлын байрны ажиллах горимын, материалын болон үйл явцын өөрчлөлт гарсан тохиолдол бүрт цаг алдалгүй ажлын байрны осол эрсдлийн үнэлгээг заавал шинээр хийх ёстой бөгөөд үргэлж үйлдвэрийн шинэ ажлын горимыг дагаж шинэчлэгдэж явна. Энэхүү үүргийг ажил олгогч хүлээх бөгөөд тухайн байгууллагын удирдлагадаа даалгавар болгон өгнө. Зарим үнэлгээний үед ажилтан дээрх аюулгүй ажиллагааны зааврыг уншсан гэсэн хариулт авсны үндсэн дээр хэрэгжих боломжтой болдог байх жишээтэй. Зөвөлгөө болон зааварчилгааг ажиллагсад ХАБЭА-н хэлтсээс хүлээн авна. Аливаа үнэлгээний үр дүнг үргэлж бичгээр үйлдэж хадгална.

Байгууллага бүр дотооддоо аюул ослын урьчилсан тооцоо, эрсдлийн дүн шинжилгээ болон түүнтэй тэмцэх арга хэмжээг боловсруулах өөрийн гэсэн арга барилтай байх бөгөөд түүнийгээ хөгжүүлж, өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлж явна. Бүх түвшний удирдлага болон ажилтан албан хаагчид нь дээрхи аргачлалыг ойлгосон, өөрсдийн үүргийг дээд зэргээр ухамсарласан байх бөгөөд


зохих хэмжээнд сургалтанд хамрагдсан байх ёстой. Ажлын байрны тодорхойлолт, эрсдлийн үнэлгээ нь гэрээт ажилчидад ч мөн хүчин төгөлдөр үйлчилнэ. Түүнийг тухайн байгууллага үйлдэх үүрэгтэй бөгөөд түүний хамрах хүрээ болон хэлбэрийг ярилцаж тохирсон байх ба өөрсдийн ажилчдыг хамарсан байвал тэдний хандлагыг ч мөн тусгаж өгнө.



Эрсдлийн үнэлгээний талаар болон жишээ загварын талаар нэмэлт мэдээллийг хавсралт 8.2-оос авна уу.

3.2.9 Хохирлыг бууруулах, арга хэмжээний дэс дараалал

Аливаа ажлын байрны тодорхойлолт, осол эрсдлийн үнэлгээг хийсний дараагаар гарч болох осол эндэгдэлийг бууруулах, аюултай хэсгийн эрсдлийг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл багасгах арга хэмжээг авна.



Зураг 5: Эрсдлийн түвшин, төрөл

Урьдчилан сэргийлэх болон хамгаалах үйл ажиллагаа нь доорхи дарааллаар явагдана. Аюул ослыг үгүй болгох, ослыг тусгаарлах, ослоос хүнийг хамгаалах техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээ юм. Дээр дурьдсан аргачлалуудаас харахад ослын эрсдлийг багасгах гэж оролдхоос гадна түүнээс зайлсхийхийг зорих ёстойг анхаарах хэрэгтэй билээ. Үүний тулд компанийн холбогдох бүх ажилчид аюулгүй үйл ажиллагааг хамгаалах арга хэмжээнд зохих сургалтанд хамрагдсан байх нь зүйтэй юм.



Зураг 6: Нөлөөллийн хэмжих шатлал

Аюул ослог бий болгогч эх үүсвэрийг хэдий чинээ эхний шатанд устгах арга хэмжээ авна төдий чинээ үр дүнтэй болох юм. Жишээ болгож доорхи авбал зохих арга хэмжээний шатлалыг оруулав.

Аюул ослоос хамгаалах арга хэмжээний шатлал дараалал	
➤	Аюул учруулж болзошгүй материалиас татгалзах
➤	Аюултай материалтай харьцах орон зайг холдуулах
➤	Аюултай материалыг тусгаарлах
➤	Аюултай тоосонцрыг соруулж авах
➤	Битүүмжлэх
➤	Ажлын горим, ажлын цаг, завсарлага
➤	Аюултай материалтай ажиллахыг хязгаарлах
➤	Хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл хэрэглэх: бээлий, малгай, хамгаалалтын нүдний шил
➤	Тусгай багаж хэрэгсэл хэрэглэх
➤	Зааварчилгаа болон сургалт
➤	Анхааруулах, хориглох, мэдээлэх тэмдэглэгээг тавих

3.2.10 Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл (XXX)

Хэрвээ ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээгээр дамжуулж эрсдлийг эхний шатанд устган, арилгаж чадаагүй тохиолдолд хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслийг зайлшгүй хэрэглэх арга зам юм. (Хөдөлмөр хамгааллын шатлалаас харна уу)

Ажлын байр бүрийн тодорхойлолт, эрсдлийн үнэлгээнд тулгуурлан тохирсон хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслийн төрөл, хэмжээг тодорхойлно. Мөн бүхий л багаж хэрэгслийн ашиглагдвал зохих хугацааг бичиж тэмдэглэх хэрэгтэй. Үйлдвэр уурхайн газрын үндсэн хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болох хамгаалалтай гутал, ажлын нүдний шил, бээлий, дуулга болон дулаан хувцас зэргээс гадна зөвхөн тухайн ажил мэргэжилд зориулагдсан онцгой хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслийг мөн хамруулна. Жишээлбэл: гагнуурын нүдний шил, агаар шүүгч маск, арьс хамгаалах битүүмжилсэн хувцас гэх мэт. Аливаа компани нь өөрийн ажилчид болон гадны зочдын эрүүл мэнд амь насыг хамгаалахын тулд үнэ төлбөргүй хөдөлмөр хамгаалалын багаж хэрэгслээр хангах ба түүнийг бүрэн зөв хэрэглэх ашиглах зааврыг танилцуулах үүрэгтэй. Мөн хэрэглэж дууссан болон ашиглах хугацаа нь дууссан багаж хэрэгслийг устгалд оруулах шаардлатай.



XXX-ийг өөрийн компанид хэрэглэх боломжийн талаархи нэмэлт мэдээллийг хавсралт 8.2-оос авна уу

Гэрээт ажилтан болон гэрээт компаний ажилчдыг тухайн компанийн ХАБЭА-н дүрмийн тухай мэдээллээр хангана. Компани нь тэдний зөв зохистой хэрэглээнд хяналт тавих үүрэгтэй.



XXX-ийг гэрээт ажилчин хэрэглэх боломжийн талаархи нэмэлт мэдээллийг хавсралт 8.3-аас авна уу

3.2.11 Ажлын байрны эрүүл ахуй

Эрүүл саруул ажилтан нь хийж буй ажилдаа сэтгэлээ шингээж ажилласнаар илүү үр дүн авчрах учраас эрүүл аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх шаардлага нь тухайн компанид чухал байр суурь эзэлдэг. Ийм учраас тухайн



германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Implemented by:

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH


Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага хөтөлбөр
Integrated Mineral Resource Initiative

хүн аливаа ажилд орохоос өмнө эрүүл мэндийн нарийвчилсан үзлэгт орж, уг ажлыг хийж гүйцэтгэхэд эрүүл мэндийн хувьд тохирох эсэхийг тогтоодог. Тиймээс ажлын байр бүрийн тодорхойлолтод тухайн ажлыг хийж гүйцэтгэгчийн эрүүл мэндийн шаардлагыг тусгасан жагсаалт багтах ёстой.



Ажилчдын эрүүл ахуй, аюулгүй байдлын шалгалтын талаар нэмэлт мэдээллийг хавсралт 8.4-өөс авна уу

Тохиолдож болох осол эндэгдэл учирсны дараа гэмтэж бэртсэн ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварыг дахин сэргээх нь үүрэг бөгөөд түүний тулд анх ажилд орсон үед тэмдэглэгдсэн эрүүл мэндийн байдлыг ашиглана.



Зураг 7: Ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллүүд

Ажилтан ажиллагсдын эрүүл чийрэг хэвээр байлгахыг дэмжиж, сөрөг нөлөөллөөс зайлсхийхийн тулд компанийн зүгээс тусгай сургалт эсвэл биеийн тамирийн өдөрлөгийг тогтмол зохион байгуулах нь үр дүнтэй байдаг. Жишээлбэл: нурууны эрүүл ахуйн курс, эрүүл мэндийн өдөрлөг, зөв хооллох зөвлөмж гэх мэт.

3.2.12 Гэмтэл ослыг мэдэгдэх, бүртгэх, арга хэмжээ авах

Том жижиг осол, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөн үйл явдал, осол үүсгэж болох үйлдэл зэргийг үргэлж цаг алдалгүй зохих хүнд нь мэдээлж, дүгнэж, баримтжуулж байх нь ирээдүйд учирч болох томоохон аюул ослыг эрт таньж, устгаж арилгахад маш чухал хэрэгсэл болдог. Энэхүү эрүүл, аюулгүй ажиллагааны шаардлагыг бичиг баримттай хөтлөх нь хуулийн шаардлагыг хангаад зогсохгүй найдвартай ажиллагааны гэрч болно.

Байгууллагын ажилтан бүр том жижиг осол эндэгдэл, осол учирч болохуйц үйл явдал, эрүүл аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөн тохиолдол бүрийг зохих шатны мэргэжилтэн болон хариуцсан ажилтан бүрт мэдээлэх үүрэг хүлээнэ. Үүний тусламжтайгаар аюул ослоос зайлсхийх боломжтой болно.




Үйлдвэрлэлийн осол аваарын тайлагналын талаар нэмэлт мэдээллийг хавсралт 8.5-аас авна уу.

Дээрх тохиолдлуудын аль нь боловч тус тусын урьчилан бэлтгэсэн анкет хүснэгтэнд бүртгэгдэж ХАБЭА хариуцсан мэргэжилтэнгээр хянагдана. Гарсан гэмтэл эндэгдэл болон түүнээс үүсэлтэй өвчлөл нь салбарын осол эндэгдлийн бүртгэлд бичигдэнэ.

суралцахдаа
доороос эхлэх –

нэмэлт
мэдээллийг
доороос эхлэх




Зураг 8: Ослын пирамид.

Дээр дурьдагдсан осол эндэгдэл түүнтэй дүйцэх үйл явдлын баримтжуулсан бичиг баримт нь хариуцсан улсын байгууллагын шаардлагын дагуу дахин нягтлагддаг. Тиймээс хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн тухайн ослын үнэмшилтэй байдлыг шалгаж үздэг. Иймд ослын газрыг ямархүү хэмжээнд шалгаж, зургаар баримтжуулахыг байгууллагын захирал болон ХАБЭА хариуцсан мэргэжилтэн хоёр хамтран шийдвэрлэнэ. Энэхүү шалгалтын тусламжтайгаар тохиолдож болох осол гэмтлээс урьдчилан зайлсхийх арга замыг бий болгоно. Мөн осол гархуйц үйл явдлыг эрт танин мэдэж дутагдлыг арилгасан тохиолдолж, учирч болох байсан хор уршгийн хэмжээнд дүн шинжилгээ хийх хэрэгтэй аж.

Тохиолдож болох осол эндэгдлийн урьчилсан дүгнэлт үнэлгээ зэрэг нь ослоос урьчилан сэргийлэх тогтолцоог бий болгоно. Үүний тулд байгууллагын удирдлага болон ХАБЭА хариуцсан мэргэжилтэн нарын тогтмол үйлдвэрийн үзлэг, зочлолт болон ажилтан, албан хаагчдыг сонсох нь шаардлагатай мэдээллийг цуглуулж олж авахад туслах юм. Үүний хажуугаар энэхүү гарсан дутагдлыг засаж сайжруулахгүй бол муугаар бодоход үүсэх байдал, түүнээс сэргийлэх арга хэмжээ, болон тэднийг баримтжуулах юм.


Ажлын байран дахь осол, ажил гэр хоёрын хооронд тохиолдсон осол, ажлын явцын жижиг осол гэмтэл болон осол гарч болохуйц үйл явдлыг судлах дүгнэх ажил нь бэлтгэгдсэн бичиг баримтын дагуу явагдана.



Зураг 15: Осол гэмтэл, осолд өртөх нөхцөл, тохиолдлыг мэдэгдэх, бүртгэх


Аваар ослын дүн шинжилгээ

Ажлын явцад зогсолт гаргаагүй жижиг гэмтэл бэртэл болон аюултай байж болох үйл явдал тохиолдсон тухайн мэдээллийн дагуу ХАБЭА хариуцсан мэргэжилтэн зохих зааврын дагуу шалгаж дүгнэлт хийнэ. Түүний тусламжтайгаар аливаа осол гэмтлийн эх үүсвэр болон хэрхэн осолд хүргэх зам зэргийг танин мэдэж, улмаар гэмтэл ослын хөгжлийн диаграммаар дүрслэх хэрэгтэй.




Зураг 16: Нөлөөлөл шалтгааны уялдаа

Гэмтэл ослын хөгжлийн диаграммын тусламжтайгаар зөвхөн гол шалтгааныг олж илрүүлэхэд чиглэх бус осол гарахад нөлөөлж болох бүх эх үүсгэврүүдийг нэгтгэх ба түүнтэй холбогдох шийдвэрлэх түлхүүрийг гаргаж тавина. Гэмтэл ослын хөгжлийн диаграмм нь тухайн нөхцөл байдлаас хамааран товч бөгөөд тодорхой байх эсхүл маш нарийвчилсан байж болно. Дээрх диаграмм нь гурван үндсэн дараалалтай байна.



Зураг 17: Шалтгааныг зураглах аргачлалын үндсэн 3 алхам



Шалтгааны дүн шинжилгээ, “загасан ясны” схемийн талаар нэмэлт мэдээллийг хавсралт 8.6-аас авна уу.

Ослын газар шалгалт хийснээр тухайн осол нь хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдснаас, үйлдвэрийн эмчийн үйл ажиллагааны болон зохион байгуулалттай холбоотой дутагдалаас үүсэлтэй болох зэргийг тогтоож хожим үүнтэй төстэй ажлын осол эндэгдэл гарахаас урьдчилан сэргийлнэ. Цаашлаад урьдын хүчинтэй байсан ажлын байрны тодорхойлолт эрсдлийн үнэлгээний үнэнд нийцэж буй эсэхийг шалгаж, засаж залруулах зүйл гарвал хийж гүйцэтгэх аргачлалын дагуу нэмэлт өөрчлөлт оруулна.

3.2.13 Тоног төхөөрөмж, машин механизм, үйлдвэрийн болон хөдөлмөрийн хэрэгсэл

Ажил олгогч бүхэн ХАБЭА-н багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэх, түүний бүрэн бүтэн байдалд хяналт тавих, мөн ашиглаж дууссаны дараа тэднийг устгах хүртэл үүргийг хуулийн хүрээнд хүлээсэн байна. Мөн ажил олгогч нь тухайн багаж хэрэгсэл, хувцас материалыг нийлүүлэхийн өмнө ажилтан бүрт таарч тохирсон эд зүйлсийн урьдчилсан жагсаалт гаргасан байна. Тухайн багаж хэрэгсэл, хувцас хэрэгслийг хэрэглэж байх явцад үзлэгт оруулж шалгах үүрэгтэй ба барилга байгууламжын аюулгүй байдалд хүртэл хяналт тавиж мэргэжлийн байгууллагаар шалгуулж байна.

Тодорхой норм стандартад нийцүүлсэн ХАБЭА-н хувцас хэрэгсэл нь хүний бие махбодийг ажлын аюулаас хамгаалах үндсэн үүрэгтэй ба түүнд дүйцэхүйц чанарын болон техникийн чадварыг эзэмшиж байх ёстой юм. Ажлын хэрэгслүүд нь олон улсын стандарт (ISO) –н болон үндэсний стандартад нийцсэн мөн Засгийн газрын зөвөлгөө чиглэлийг зөрчилгүйгээр хийгдсэн байх нь зүйтэй. Олон улсын стандартын байгууллага нь (International organization for Standardization - ISO) олон улсын худалдааны байгууллагын гаргасан зөвлөмжийн дагуу норм стандартыг гаргадаг. Уг норм стандарт нь бүтээгдэхүүний шинж чанар болон эрүүл ахуйн шаардлагыг тусгах бөгөөд тэрхүү бүтээгдэхүүнийг хэрхэн зөв ашиглах зааврыг мөн хавсаргадаг.

Цаанаас баталсан норм стандартыг баримтлан ажилласнаар эрүүл аюулгүй ажлын байр болон чанартай бүтээгдэхүүнийг бий болгодог. Мөн ажлын байрны осол гэмтлээс болон мэргэжлээс шалгаалах өвчин зэргээс үүсэх том хэмжээний зардлыг хэмнэх боломжийг олгож байдаг.

Олон улс даяар ижилхэн нормыг авч хэрэгжүүлснээр өөр өөр үйлдвэрлэгч нар адил хэмжээний чанартай бүтээгдэхүүн үйлвэрлэх боломжтой юм. Энэ нь үйлдвэрлэгчид өөрийн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн хэрэглэгч компанид чанартай бүтээгдэхүүн ажилчиддаа санал болгох давхар давуу талыг бий болгож байгаа юм.

3.2.14 Хортой болон аюултай бодисын удирдлага

Аливаа компани нь үйлдвэрлэлдээ аюултай бодис материал ашиглаж байгаа тохиолдолд түүний зөв хадгалалт болон зөв болгоомжтой ажиллах аргачлалыг боловсруулах ёстой болон түүнээс үүдэн үүсэж болох хор хөнөөл, аюулыг урьдчилан судалж дүгнэж, аюулаас зайлхийх, хамгаалах арга хэмжээг тодорхой болгоно. Хорт болон аюултай бодистой ажилладаг ажилтан албан хаагчдыг зохих сургалтанд хамруулж дадлагжуулна.

Хорт болон аюултай бодис материалаас үүдсэн өвчлөл нь үйлдвэрийн горимыг алдагдуулж, эдийн засгийн хохирол учруулаад зогсохгүй тухайн компанийн нэр хүндэд муугаар нөлөөлөх магадлалтай. Тийм учраас хортой болон аюултай материалтай харьцах тогтолцоог бий болгож хариуцлагыг тодорхой болгох нь чухал юм. Үүний нэгэн чухал хэсэг болох аюултай бодисыг таних тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтой болгож нэгдсэн ойлголтыг бий болгох хэрэгтэй байдаг.

Нэн түрүүнд тухайн байгууллагад ашиглаж байгаа бүх хорт болон аюултай материалын хэмжээ тоо, байршил зэргийг судалж гаргах. Түүний дараагаар тухай материалын үүсгэж болох аюул ослыг тандан судлаж түүнээс хамгаалах арга хэмжээг хэлэлцэж гаргах бөгөөд аюултай материалыг тэмдэг тэмдэглэгээг хийж зохих ажилтангуудад зааварчилгааг өгсөн байх ёстой.



Зураг 9: Эрүүл ахуйн хамгааллын тэмдэглэгээ

Аюултай материалыг тээвэрлэх, хэрэглэх, хадгалах болон устгах аргачлалыг холбогдох аюулгүй ажиллагааны зааварчилгаа нь тухайн материалыг үйлдвэрлэсэн газраас дагалдах ба тэр нь хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэргийг агуулсан байна. Тэрхүү зааварчилгааг хэрэглэгч бүр ойлгохуйц хэлбэрээр дүрслэн үзүүлнэ.

Энэ тохиолдолд компанийн зүгээс тухайн бодис материалын аюулгүй ажиллагааны зааварчилгаа нь тус улсын одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид заасан заалтыг зөрчөөгүй, мөн түүнтэй харилцах ажилтан нь аюулгүй ажиллагааны зааврыг уншиж ойлгосон болон зохих сургалтад хамрагдсан эсэхийг хянах үүргийг хүлээнэ.

Хортой болон аюултай бодистой харилцах менежментийн системийг зөвхөн тухайн чиглэлээр сургалтанд хамрагдсан тодорхой ойлголттой мэргэжилтэн нэвтрүүлж хэрэгжүүлэх ба тэрхүү хэлтэс нь тухай материалыг зөв зохистой хэмжээгээр дээрээс тусгагдсан зорилгын дагуу ашиглаж байгаа эсэхийг шалгаж хяналт тавих ба шаардлагатай гэж үзвэл зөвшөөрөл олгож болно. Мөн компанид шинээр хорт болон аюултай бодис материал хэрэглэх шаардлага гарвал дээр дурьдсны дагуу бүртгэж, тэмдэглэж зохих зааварчилгааг өгч ажиллана.

3.2.15 Гэрээт байгууллагууд, нийлүүлэгчид, түнш болон зочид

Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журмыг гэрээт ажилтан, ханган нийлүүлэгч, хамтран ажиллагч, зочлогч бүр сахин хэрэгжүүлэх үүрэгтэй. Аливаа ажлыг гүйцэтгэгч дээрх байгууллагууд нь гэрээг хийхийн өмнө хэрхэн аюулгүй ажиллах зааварчилгаатай танилцсан байна. Гэрээт ажилтан болон гэрээт компанийн ажилтан бүрийг тодорхой сургалтанд хамруулах эсвэл ХАБЭА-н мэргэжилтэн зааварчилгааг тухайн ажлын байранд өгсөн байна. Үүний хүрээнд ХАБЭА-н мэргэжилтэн шаардлагатай хөдөлмөр болон эрүүл ахуйн багаж хэрэгслээр хангах ба түүнийг зөв зохистой хэрэглэж байгааг хянах үүрэгтэй. Мөн дээрх үйл ажиллагааг бичиг баримт бүрдүүлэн хөтлөн явуулна.

Бүхий л ХАБЭА-тай холбойтой дүрэм журам, план зураг, тэмдэг тэмдэглэгээ болон зааварчилгаанууд нь гадны гэрээт компаниуд болон гэрээт ажилтнуудад зориулсан зааварчилгааны дэвтэрт багтсан байх ёстой. Үүний тусламжтайгаар гэрээт компани нь зөвхөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай мэдээлэл авахаас гадна тухайн компанийн ХАБЭА-н итгэмжлэлийн түвшин болон ажлын байрны тодорхойлолт, эрсдлийн үнэлгээний талаар мэдээлэл авч болно. Мөн уг зааварчилгаанд холбогдох ХАБЭА-н мэргэжилтэнүүдийн жагсаалтыг хавсаргана. Энэхүү бүх үйлчилгээ зөвхөн хүн, байгаль болон хүний үнэт зүйлсийг хамгаалах эрхэм зорилготой байна.

3.2.16 Баримт бичгийн шалгалт, мэдээллийн удирдлага

Байгууллага бүр өөрийн хэрэгцээндээ гадаад болон дотоод журам хэрэглэдэг. Энэхүү хууль захирамж, өөрсдийн боловсруулсан дотоод дүрэм болон сайн

дураараа нэгдсэн санамж бичиг зэргийг ХАБЭА-н үйл ажиллагаандаа ашигладаг. Байгууллагын дотоод журмыг хуулинд заасан чиглэлийн дагуу өөрийн онцлогт тохируулан боловсруулж болно. Үүний тулд хариуцлагын тогтолцоо болон үүргийн үйлчлэлийн хүрээг тогтоож бүрэн бүтэн байдлыг судлана. Үүний үндсэн дээр ирээдүйд хэрэгжихэд дутагдалгүй, бодлогын хувьд төгс, үйл ажиллагаанд бүрэн нийцсэн байгууллагын бүхий л түвшинд сайтар нөлөөгөө өгөх боломжтой, ойлгомжтой хэлбэрээр боловсруулна. Тухайн баримт бичгийг хамт олонд нээлттэй байлгаж уншиж танилцсны дараагаар засаж сайжруулж эсвэл нэмэлт өөрчлөлт оруулж нэгтгэн батлана.

3.2.17 Гэнэтийн ослоос хамгаалах, төлөвлөх

Аливаа байгалийн гамшиг болон гэнэтын ослын үед (жишээлбэл: байшин барилгын гал түймэр, олон хоног үргэлжлэн орсон борооны улмаас үүсэх ил уурхайн мөргөцгийн гулсалт гэх мэт) гамшгийн үед хэрэглэх гэнэтийн ослын аврах төлөвлөгөөг байгууллага бүр үйлддэг. Үүний тусламжтайгаар гамшгийн үед хүн болон нийгмийн үнэт зүйлсийг хамгаалж, болзошгүй аюулыг багасгадаг. Энэхүү төлөвлөгөө нь осол гармагц хэрэгжиж эхлэх боломжтой байх бөгөөд тайван цагт учирч болох тохиолдлуудыг судалж, үүний үндсэн дээр төлөвлөгөөг боловсруулсан байна. Энэхүү гэнэтийн ослын төлөвлөгөөний эрхэм зорилго нь хүний амь насыг хамгаалах, түүний дараагаар тохиолдсон аюул ослыг тогтворжуулах болон учирч болох хохиролыг бууруулахад оршино.

Гэнэтийн ослын үед авах боломжит арга хэмжээнүүд	
➤	Осолд өртөгсөдөд шуурхай анхааруулга өгөх болон аюулаас тусгаарлах
➤	Боломжит аюулын гарцыг бий болгох, тэмдэглэх
➤	Осол болон гал түймрийн үеийн аврах төлөвлөгөөг боловсруулах
➤	Аюулын үед тусгай хамгаалалтай өрөө тасалгаа болон цугларах цэгийг бий болгох
➤	Аюулаас аврах баг, анхны тусламж үзүүлэх болон тусгаарлах багийг сургалтанд хамруулах
➤	Туршилтын аюулын түгшүүрийн дадлага хийх
➤	Зайлшгүй шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг байрлуулах. Жишээлбэл: галын дохиолол, галын хор, анхны тусламжын хайрцаг гэх мэт.


- Үйлдвэрийн болон улсын аврах албаныханд зориулсан аюулын үед ажиллах ойлгомжтой болон нэгдсэн мэдээлэлтэй байх.

Гэнэтийн ослын үед аврах төлөвлөгөөг боловсруулахад доорхи есөн алхамыг баримталвал зохистой байдаг.

- 1 • Аюул ослын шалгалт, эрсдлийн нөхцөл байдалд бэлэн байгаа байдлыг хэсэг, үйлдвэрийн цех бүртээ тогтоох
- 2 • Өөрийн байгууллагын хүчин чадал, боломж, нөөцийг /хүн, тогтолцоо, багаж техник/ тогтвортой болгох, байлгах
- 3 • Улсын аврах үйлчилгээний байгууллагатай холбоотой ажиллах /гал түймэр, түргэн тусламж/ өөрийн байгууллага/ажилчдын мэдлэгийг тогтмол сайжруулах
- 4 • Өөрийн үйлдвэр, байгууллагын аврах төлөвлөгөөнд тусгай журам, дүрэм боловсруулах /ж/нь аврах, тусламж үзүүлэх төлөвлөгөөг ISO 2360:2009-той уялдуулах/
- 5 • Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх болон хамгаалах арга хэмжээнүүдийг бий болгох
- 6 • Аврах төлөвлөгөөгөө улсын онцгой байдал, аврах үйлчилгээнд уялдуулах
- 7 • Ажилчдыг тогтмол сургалтанд хамруулснаар үүргээ биелүүлэх чадвар нэмэгдэнэ /анхны тусламж хүргэх, аюулаас гаргах, түймэр унтраах/
- 8 • Аврах сургуулилтыг тогтмол хийж, аврах төлөвлөгөөний хэрэгжих боломж, нөлөөллийг эргэн шалгаж, ажилчдыг тодорхой тохиолдол, нөхцөлд хэрхэн хандах сургалтанд хамруулах
- 9 • Аврах сургуулилтаас олж авсан туршлагад үндэслэн аврах төлөвлөгөөг тохируулан өөрчилж, нэмэлт араг хэмжээнүүдийг боловсруулах

1. Тухайн цэгт тохиолдож болох аюул ослын урьдчилсан эрсдлийн үнэлгээ
2. Ослыг арилгах өөрийн байгууллагын хүн болон техникийн бэлэн байдал жишээлбэл: гал команд, байгууллагын сэргийлэх, уурхайн эмч гэх мэт
3. Улсын гал команд, цагдаа, түргэн тусламжийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулж, барилга байгууламжийн төлөвлөлтийг ойлгомжтой хялбар болгох, түүний тусламжтайгаар улсын түргэн тусламж цаг алдалгүй аюул осол гарсан газар төвөггүй хүрэх.
4. Осол аюулын үед ажиллах төлөвлөгөө, зураг зэргийг олон улсын стандартад нийцүүлэх.
5. Хүний амийг аврах арга хэмжээ болон ослыг устгах төлөвлөгөө.
6. Байгууллагын өөрийн ослын үед ажиллах план, төлөвлөгөөг улсын аврах албаны түвшинд хүргэх.
7. Үйлдвэрийн анхны тусламж болон онц байдлын үед ажиллах аврагч нарын сургалт, семинарууд зохион байгуулах.
8. Туршилтын сургалтын зориулалтай түгшүүр зарлаж, ажилчдын аюул ослын үед хэрхэн хандах хандлагыг сайжруулах.
9. Бүтцийн болон зохион байгуулалтын өөрчлөлт болон туршилтын түгшүүрийн давтлагаас цуглуулж авсан мэдээллэлд тулгуурласан засвар сайжруулалтыг аюул ослын үед ажиллах төлөвлөгөөнд оруулж өгнө.

Доорхи бүдүүвчид болзошгүй аюул ослыг харуулав.



Зураг 10: Онцгой байдлын төлөвлөгөө зохиоход гарч болзошгүй эрсдлүүд

3.2.18 Хоёрдох тулгын чулуу - нөхцөл байдлын дүн шинжилгээ


Хоёр дахь чухал шалгалт бол одоо байгаа байдлын шалгалт юм. Энэ нь яг одоогийн байгаа нөхцөл байдлыг бүртгэж авах явдал юм. Хөндлөнгийн шалгалтын баг тухайн байгууллагын удирдлагын тусламжтайгаар тухайн хоёр шалгалтын үр дүнг бүртгэн авч нарийвчилсан схемийг гаргана. Тухайн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах хүрээнд бүтэц, зохион байгуулалт, техникийн хэрэглээ болон ажиллагсдын мэдлэгийн өнөөгийн байдалд эхний шалгалтыг хийж үнэлгээг өгнө. Үүний дараа үйлдвэр ба уурхайн тухай бүрийн ажлын байранд очиж удирдлага болон ажилчидтай ганцаарчилсан ярилцлагыг явуулна. Энэ нь төлөвлөж буй төлөвлөгөөнд чухал нөлөөтэй байдаг. Ярилцлага нь байгуулага доторх мэдээллийн урсгал, хариуцлагын тогтолцоо,

ажилчдын чадамжын хэлхээ холбоо, дараалал зэрэг тодорхой зорилготой асуултанд хариулагдсан өргөн агуулгатай байдаг. Үүний тусламжтайгаар байгууллагын бүтэц болон үүрэг хариуцлагын схемийг гаргаж болно. Хэрэв тухайн компани нь Олон улсын ISO 9001 эсвэл UMS 14001 –г аль хэдийн нэвтрүүлсэн байгаа тохиолдолд ихэнх мэдээлэл нь дүйцэгддэг давуу талтай байдаг.

Одоо байгаа байдлын шалгалын хүрээнд одоогийн чадамжийн хэмжээ маш тодорхой харагдах бөгөөд ямар хэм хэмжээгээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тал дээр анхаарах, өөрчлөх ёстой зэргийг үзэж болно. /Хуудас 43/ Чухал мэдээлэл болон өгөгдлийн гарал үүсэл болон түүний боловсруулалтын томъёололт зэрэг нь тодорхой байх ёстой бөгөөд Хэрэгжилтийн түлхүүр шалгуур (KPI) –ийг боловсруулах үед чухал үүрэгтэй.

3.2.19 Гуравдахь тулгын чулуу - байх ёстой ба байгаа байдлын дүн шинжилгээний харьцуулалт

Энэхүү хоёр шалгалт, дүн шинжилгээний тусламжтайгаар өгөгдөлд үнэлгээ өгсөнөөр компанийн хөндлөнгийн шалгалт дуусгавар болно. Энэ нь дээр дурьдсан гурав дахь үндсэн хэсэг болно. Үүний дараа тухайн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн системд хэрхэн өөрчлөлт оруулах, хаана юун дээр анхаарах вэ зэрэг нь тодорхой болдог. Энэ бүхэн нь эцэстээ байгууллагын нөөцийн зарцуулалтын чухал байдлын зэрэглэлийг тодорхойлоход тусалдаг бөгөөд цаг болон мөнгө хэмнэх боломжтой юм. Компанийн хөндлөнгийн шалгалтын үр дүн байгууллагын удирдлагад нэн даруй хүргэнэ. Байгууллагын хөдөлмөр хамгаалалын ажилтан болон удирдлагууд хамтран өөрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зорилт болон дээр хийгдсэн хоёр шалгалтын үр дүнг тэнцвэржүүлэх ажиллагаа явуулна.



Зураг 20: Байх ёстой ба байгаа байдлын дүн шинжилгээний харьцуулалт

Энэхүү тэнцвэржүүлсэн адилтгалын үр дүн нь аль болон байгууллагын дотоод үзэл баримтлалд нийцсэн байх ёстой бөгөөд урт хугацааны зорилгод хүртэл тусгалаа олсон байх ёстой. Эцэст нь хөдөлмөрийн аюулгүй байдал, ахуйн системд хийсэн хөндлөнгийн шалгалтын үр дүнгийн тайланг бичнэ. Энэхүү тайлан бичигдэх ерөнхий схемийг зургаар харуулсан бөгөөд доорхи таван шаардлагыг хангасан тайлан байвал зохино.



ХАБЭА-н төрөл, арга хэрэгслийн талаархи нэмэлт мэдээллийг хавсралт 8.8-аас авна уу.

Тодорхойлогдсон зорилго болон түүнээс үндэслэсэн зорилт, даалгаврууд нь хамаарагдах хүн бүрт бичгээр нийтийн хүртээл болсон байна. Үүний дараагаар компанид хөдөлмөрийн аюулгүй байдлын удидлагын системийг нэвтрүүлэх эсвэл хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хамгаалах арга хэмжээг явуулж болно. Төслийн удирдлагууд төслийн хэрэгжилтийн явцыг дээрх хийгдсэн шалгалтын тусламжтайгаар цаг үргэлж шалгаж явах үүрэгтэй. Уг шалгалтаар төслийн үр өгөөж болон зорилгын өөрчлөлт гарч байгаа эсэхийг хянана. Хэрэв шаардлагатай тохиолдолд төслийн төлөвлөгөөг засварлаж сайжруулна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан нэгжүүдийн хоорондийн хамтын ажиллагаа нь хөдөлмөрийн аюулгүй байдлын удидлагын системийн нөлөөллийн чадамжийг сайжруулж улмаар хөдөлмөр хамгаалалын зааварчилгаа нь бодит байдалд нийцсэн байдлаар тодорхойлогдоно. Энэ бүхнийг өдөр тутмын ажил хэрэг болгохын тулд хөндлөнгийн шалгалтын баг гаргах зааварчилгаа бүрийг тухайн үйлдвэрлэлийн байдалд тохируулан хөгжүүлсэн байх ёстой. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаатай шууд болон шууд бусаар холбоотой хүснэгт, тоо баримт, зөвшөөрөгдөх хэмжээ зэргийг ил тод байлгах нь зүйтэй.

3.3 Хэрэгжилт

Аливаа байгууллагын дээд удирдлага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хэрэгжүүлэх нэгжүүд, техникийн зааварчилгаа, зөвшөөрөгдөх хэмжээ болон хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэлийг хөгжүүлж бий болгох, зөвшөөрлийг олгох, зохион байгууллах үүргийг хүлээнэ. Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой мэдээллийн урсгалыг байгууллагын дотоод сүлжээ, зарлал мэдээлэл, уулзалт хурал зохион байгуулж бусдад түгээх нь давуу талтай байна. Энэхүү үйл ажиллагааг зөвхөн байгууллагын дотогш чиглэлтэй зохион байгууллаад зогсохгүй мөн гадагш чиглэлүүлсэнээр тухайн байгууллагын сурталчилгаа (PR), түүнчлэн компанийн нийгмийн хариуцлагыг олон нийтийн дунд дэлгэрүүлэх бөгөөд хамтран ажилладаг гэрээт компаниуд болон гадны зочдын хөдөлмөрийн аюулгүй байдлын дотоод дүрмийг хангаж ажиллахад чухал байдаг.

Гэрээт компаниуд ХАБЭА-н зааварчилгааны тусламжтайгаар гэрээгээр ажил гүйцэтгэж буй компани болон гэрээт ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин нь үндсэн ажилчдын орчинтой адил болж үйлдвэрийн аюулгүй ажиллагаанд таатай байдлыг бий болгоно.

Цаашлаад гэрээт ажил гүйцэтгэгч компани нь тухайн ажилд шаардагдах шаардлагыг хангах зохих тооны ажиллагсадыг бүрдүүлсэн байх үүрэг хүлээнэ.

3.3.1 Удирдлага ба ажилчдын нэгдмэл байдал

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоог өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэх явцад удирдлагууд, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтнууд болон нийт ажилтнуудыг шинэ бодлогод тохирсон сургалт семинарт зайлшгүй хамруулах ёстой. Эл сургалтаараа салбарын шинэ мэдлэгийг дамжуулан мэдээлэх үүрэгтэй. Үүнийг зохион байгуулсанаар байгууллагын ажилтан бүр ажлын байрандаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг ухамсартайгаар даган мөрдөж улмаар байгууллагын ажил цогц аюул осолгүй явагдаж, түүний тусламжтайгаар ажлын амжилт баталгаажна. Үүний тулд ажилтан бүрийн гүйцэтгэх ажлыг болон түүний хэмжээг тохируулж, зохих сургалтыг зохион байгуулах нь зүйтэй. Ингэснээр ажилтан бүр өөрийн ажлыг эрүүл аюулгүй гүйцэтгэх боломжтой болно.

Ийнхүү бүрэлдсэн нөхцөл байдлыг албан ёсны тогтмол сургалт семинар зохион байгуулах замаар тогтоож, хянаж байх ёстой. Ажлын байрны аюулгүй байдлын дүрэм ёсоор сургалт семинарт хамрагдах тоог гаргана. Байгууллагын удирдлага болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан хамтран зөвшилцөж Хэзээ? Хэн? Хэдий хугацаагаар? сургалтанд хамрагдах ёстой болон сургалт бүрийн агуулгыг тодорхойлно. Үйлдвэрийн бүх ажиллагсад эхний

ээлжинд суурь мэдлэг олгох сургалтад хамрагдсан байх шаардлагатай. Үүнд сургалтын агуулга сургалтанд оролцож буй ажилчдын тухайн ажлынх нь онцлогт тохирсон байх явдал мөн чухал юм. Ингэснээр тухайлбал зөвхөн албан конторт ажилладаг ажилтан гагнуурчины аюулгүй ажиллагаанд хамааралтай эрсдэл болон аюулын тухай мэдээлэлтэй танилцхаас гадна, гагнуурчины ажлын аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллын мэдлэгтэй болж чадах юм. Үүний тусламжтайгаар нийт зохион байгуулагдвал зохих сургалтын тоог цөөрүүлэх боломжтой аж. Сургалтууд нь мөн олон төрлийн аргаар зохиогдвол зүйтэй юм. Энэ нь мэдээж хэрэг гэрээт ажилчдыг ч мөн хамрана. Үүний үндсэн дээр гэрээт ажилчид нь ХАБЭА-н зааварчилгаа болон дүрмийг дагаж мөрдөх боломжтой болно.

Тогтмол явагддаг төрөл бүрийн зааварчилгааны аргачлалууд болон сургалт семинаруудын хажуугаар өдөр тутмын таван минутын ярилцлага зэргийг заншил болгох нь үр ашигтай байдаг. Аливаа ажилтан ажлын байрны тодорхойлолт, эрсдлийн үнэлгээг дагаж мөрдөхийн хажуугаар ажил эхлэхээс өмнө тухайн орчин, ажиллах дараалал, боломжит эрсдэл, өөрийгөө болон бусдыг хамгаалах хөдөлмөр хамгаалах хэрэгсэл зэргийг богино хугацаанд ажиглаж үнэлгээ өгөх нь зүйтэй. Үүнийг (сүүлийн мөч дэх эрсдлийн үнэлгээ) эсвэл 5-ыг авах зарчим ч (зогс – хар – үнэл – удирд – аюулгүй байлга) гэж ч нэрлэдэг байна.



[Сүүлийн мөч дэх эрсдлийн үнэлгээ, маягтын талаар нэмэлт мэдээллийг хавсралт 8.12-оос авна уу.](#)

3.3.2 Үйл ажиллагааны явцтай уялдуулах, удирдан зохион байгуулах

Аливаа ажил олгогч нь ХАБЭА-н зохион байгуулалт болон түүнийг дагаж мөрдөж байгаа байдлыг хянах үүрэгтэй бөгөөд гаргасан үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны зааварчилгаандаа хариуцлага үүрнэ. Хүн болон байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлж болох аливаа үйл ажиллагааг олж тэмдэглэн тохирсон осол эндэгдэлгүй ажиллах орчныг бүрдүүлнэ. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн системийг нэвтрүүлэх аргачлалыг дээрх аргачиллаар хийж гүйцэтгэнэ. Аливаа ажилтан хэвийн бус эрсдэлтэй ажил гүйцэтгэх тохиолдолд тусгай зөвшөөрөл авах ёстой. Энэхүү зөвшөөрлийн агуулга нь үүсэж болох аюул ослоос сэргийлэх, хамгаалах арга замууд гэх мэдээлэл байх бөгөөд үүний тусламжтайгаар эрсдлийг дахин бууруулах боломжтой. Жишээлбэл: Тэсрэх

бодис, шатах ноцох материал, өндөр байгууламжид эсвэл ажлын зай багатай давчуу объект гэх мэт.



Хөдөлмөр эрхлэлтийг зөвшөөрөх маягтын талаар нэмэлт мэдэлийг хавсралт 8.13-аас авна уу.


3.3.3 Бүтэц зохион байгуулалттай уялдуулах

Компанийн удирдлага зохион байгуулах үүргийнхээ дагуу хүний болон үйл ажиллагаанд чиглэгдсэн хариуцлагуудыг тодорхой болгох ёстой. Энэ нь ихэвчлэн албан тушаалын хүснэгтчилсэн дарааллаар (organigram) хийгддэг. Түүнд нь хариуцлагын дэс дарааллыг тодорхойлсон байх ба тухайн нэгж бүрийн бүтцийг илэрхийлсэн байдаг. Албан тушаалын хүснэгтчилсэн дараалалд тухайн албан тушаалын тодорхойлолт эрх үүрэгтэйгээ нарийн зааж өгсөн байна. Энэ нь мэдээж ХАБЭА-н системд ч мөн адил хамааралтай. Энэ утгаараа бүх гэрээ хэлцэлүүд тохирох үндсэн шаардлагуудыг дагаж мөрдөхийг шаарддаг. Мөн үүнд үүрэг, компанийн урдаа барьдаг мөрдлөг (тохирох ХАБЭА-н тогтолцооны стандартуудтай) ч хамааралтай.

Компанийн хэмжээ, бүтцээс хамаарч ХАБЭА-н системийн хариуцлагатай албыг бий болгох ёстой. Энэ хэлтсийн үүрэг даалгавар нь ХАБЭА-н системийг авч явах, компанийн удирдлагад ХАБЭА-н системийн бүтээмжийн талаар тайлагнах, аюулыг нягтлан дүгнэх болоод арга ажиллагааны зааварчилгаа, үйлдвэрийн ажиллагааны заавар зэргийг боловсруулах, нэгдсэн сургалтын материал бэлтгэж тараах, мэргэшсэн мэдлэгийг бусдад түгээх болон өөр хоорондоо харилцах арга хэрэгслүүдэд тогтмол санаа тавих зэрэг юм. ХАБЭА-н системийн төвийн зохион байгуулалтын үндсэн зорилго нь компанийн нийт хүрээнд нэгдсэн стандартчилалыг бий болгох явдал юм.

Төвийн зохион байгуулалттай хөдөлмөр хамгааллын хэлтэс нь ХАБЭА-н системийн шинжээчдэд (жишээ нь аюулгүй байдлын менежер, мэргэжилтэн, зөвлөхүүд) давхар дэмжлэг үзүүлж байдаг. Шинжээчдийг нэг талаас аливааг өргөжүүлэгч эсвэл өсөн нэмэгдүүлэгчид тооцогддог. Нөгөө талаас баг хамт олонтой харьцах харилцаа, ХАБЭА-н тогтолцооны асуудалд хандах хандлага болоод харилцан ойлголцлоор дамжуулж байр суурь нь сайжирдаг.

Байгууллагын зохион байгуулалтын бүдүүвч



Зураг 21: Жишээлсэн албан тушаалын шатлал

3.3.4 Харилцаа холбоо, хамтын ажиллагаа

Харилцаа холбоо, хамтын ажиллагаа нь тухайн байгууллын ХАБЭА-н амжилтын гол тулгуур хүчин мөн. Мэдээлэл тархалт, харилцааны хэлбэр нь хүн бүрт ойлгомжтой байх ёстой. Оролцогч бүх талууд, ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбоотой бүхий л үйл явдлыг хуульд заасны дагуу мэдэгдэх үүргийг хүлээнэ. Ингэснээр хэрэгжүүлж буй арга хэмжээний үр ашгийг жинхэнэ утгаар нь хүртэнэ. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай сэдвээр компаний аль ч түвшинд цаг алдахгүй үргэлж харилцах боломжтой байх бөгөөд ажилтан бүрт хүртээмжтэй харилцааны хэлбэрээр явагдана. Тухайлбал, сургалт, семинар, илтгэл, видео бичлэг, зураг үзүүлэн гэхчилэн.

Үүнд мэдээллийг цааш дамжуулах харилцаа холбооны зохицуулалтыг тодорхой тайлбарлаж баримтжуулна. Концерны удирдлагын (Дээрээс доош зарчим), зүгээс мэдээллийг (хууль тогтоомж, ХАБЭА-н системийн стандартууд шиг) цааш


дамжуулахын хажуугаар (хууль тогтоомж, ХАБЭА-н системийн стандартууд шиг) заавар зөвлөгөө, баримтуудыг доороос дээш (доороос дээш зарчим) нь чиглүүлэх боломжийг бий болгох ёстой.

Компанийн ажилчин бүр, цаашлаад гэрээт болон гадны компаниуд аюулгүй байдалтай бүхий үйл явцыг (осол, аюултай нөхцөл байдал, хамгаалалтгүй орчин г.м.) зохих стандартын дагуу мэдэгдэх үүрэгтэй. Үүний тулд бүртгэх анкетыг (ослын мэдээллийг бүртгэх анкет) үйлдэж түгээж мөн зохих хариуцлагатай харилцагчийг томилж бусдад танилцуулсан байна.



Тайлангийн загварыг хавсралт 8.14-өөс харна уу.

Иймд мэдээллийг цуглуулж, цааш нь түгээх хэрэгслийг бий болгох нь чухал юм. Үүнд компанийн дотоод сүлжээ (ослыг бүртгэн тэмдэглэх цахим анкет, баталгаатай бус нөхцөл байдал, сайжруулах санал, цахим сургалт г.м.), онцгой тохиолдлыг харуулсан үзүүлэнгүүд (дуу чимээний өдөр г.м.), зааварчилгааны зурагт самбар, хүчинтэй байгаа мэдээллийг агуулсан статистикийн самбар (осолгүй өнгөрсөн өдрийн тоо г.м.) үзэсгэлэн болоод арга хэмжээний өдрүүд, үйлдвэрийн дотоод үйл ажиллагаанд зориулсан сонин сэтгүүл, жил бүрийн тайлан болоод тогтмол гаргадаг мэдээллүүд орно. ХАБЭА-н системийн асуудлын байр суурь нь бусад байгаль орчин, санхүү, чанарын г.м. сэдвүүдтэй ижил түвшинд байхын тулд дээрх мэдээллийн хэрэгслүүд чухал. ХАБЭА-н тогтолцоонд тулгарч байгаа бүхий асуудлууд компанийн бүхий л шатанд хамааралтай.



Зураг 11: Мэдээллийн урсгал

ХАБЭА нь хөдөлмөрийн үндсэн нэг туслах хэсэг, ХАБЭА-н тогтолцоог нэвтрүүлэхэд компанийн бүх ажилчдын (дээд удирдлагаас эхлээд удирдах боловсон хүчин ба энгийн ажилчид хүртэл) үүргийг урьдаас сануулсан байх ёстой. Ингэсний дараа л бүх хүмүүсийн оролцоотойгоор зорьж буй ХАБЭА-н тогтолцоог хэрэгжүүлэх, нэвтрүүлэх зорилгодоо хүрч чадна. ХАБЭА-н тогтолцоотой холбоотой тодорхой нэг зорилгод тулгуурласан тогтмол амжилтанд хүрэхийн тулд ажилчдын урам зоригийг бадраах арга хэрэгслийг ашиглах ёстой. Алдаа дутагдал гаргах үед зэмлэх, сануулах арга хэмжээний хажуугаар юуны өмнө аюулгүй байдалд чиглэсэн эерэг идэвхи санаачилгыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Иймэрхүү арга хэмжээ нь хамгийн багадаа л зөв зохистой, үлгэр дууриаллыг сайшаан дэмжих замаар эхэлж, цаашлаад онцгой сайн үлгэр дууриалалтай ажилтанг шагнаж байдлаар өргөждөг. Жишээ нь: үйлдвэрлэлд нэвтрүүлж болмоор ажлын үр өгөөжийг сайжруулах санал санаачилга гаргасан ажилтанг дэмжин мөнгөн урамшуулал олгох, эсвэл батламж олгох г.м.). Иймэрхүү урамшууллын систем нь мөнгөн хэлбэрээр удирдах албаар дамжин зохицуулагдаж болох ба хэлтсийн бүтээмжийг дээшлүүлэх нэг хүчин зүйл болдог.

Үйлдвэрийн дотоод харилцаа болон дотоод илэрхийллийн хажуугаар төр болон оролцогч талууд гэж нэрлэгдэх гадны субьекттэй мэдээлэл солилцох болон түгээхэд тодорхой бүтэц зохион байгуулалт, ажлын арга барилтай болох хэрэгтэй. Энэ нь ямар бичиг баримтыг ямар тохиолд хэнд илгээх гэх зэргийг

тодорхой болгоно гэсэн үг юм. Тохирох бичиг баримтууд болон мэдээллийг хооронд нь харьцуулдаг байх хэрэгтэй юм (хүчинтэй байдлыг шалгах гэсэн үг). Тийм учраас үүнийг ХАБЭА-н системийн арга зүйн зааварчилгааг үйлдэх явцад л тусгаж баримтжуулах ёстой байдаг.

Үүний тулд олон талын асуудлыг (ХАБЭА-н систем, байгаль хамгаалал, гал түймэр г.м.) хариуцсан төр засгийн байгууллагын албаны хүмүүсийн (улсын байцаагч г.м.) маягт хүснэгтийг хийж ашиглах нь зүйтэй. Цаашилбал энэхүү сэдэв сэдвээр нь ангилсан хүснэгтэнд шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг (тохирох аюулгүй байдлын мэдээлэлтэй хорт бодисын мэдээллийн сан г.м. (*Material Аюулгүй ажиллагаа Data Sheets (MSDS)*) интернэт болон мэргэжлийн сонин сэтгүүлд байршуулж болох аж.

ХАБЭА-н системийн хүрээндэх харилцааны нэгэн чухал хүчин зүйл бол ололт амжилтыг тодорхойлох явдал юм. Үүнийг дотоод гадаад гэлтгүй аль алинд нь мэдэгдэх ёстой. Учир нь иймэрхүү байдлаар ажилчдын сэтгэл хангалуун байдлыг сайжруулаад зогсохгүй компанийн аюулгүй байдлын орчин тойрны харилцаа холбоог бэхжүүлж өгдөг. Нөгөө талаар энэ нь компанийн олон нийтийн дунд эерэг дүр зураг бүхий имиджийг өргөж өгдөг. Өөрөөр хэлбэл, ХАБЭА-н тогтолцооны ач тус авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь компанийн нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагыг тодотгож байгаа юм. Ялангуяа хөрөнгө оруулагчид үйлчлүүлэгчид эдийн засгийн өсөлт үр өгөөжийг сонирхохын зэрэгцээгээр компанийн байгаль орчин, ХАБЭА-н салбарынхаа зорилго чиглэлд хүрч чадаж байгаа эсэхийг бас давхар сонирхож байдаг. Тухайлбал тогтмол шинээр үүсэн бий болж буй зээлдэгч болон хөрөнгө оруулагч байгууллагуудад байгаль орчин, ХАБЭА-н систем, компанийн нийгмийн хариуцлага чухал сэдвүүд юм. Энэ бүгд нь тухайн компани нь олон улсын стандартыг нэвтрүүлсэн компани болох, үүсэн буй болж буй ХАБЭА-н системийн стандартуудыг мөрдөх үүрэг хүлээнэ гэсэн үг.

3.4 Хэрэгжилтийн хэмжүүр

Дээр дурьдсан мэдэгдэх, тэмдэглэн бүртгэх арга зүйн тусламжтайгаар олон чухал мэдээллийг цуглуулж болно. Олон янзын эх сурвалжаас (асуулга, санхүүгийн алба, хүний нөөцийн албаны мэдээлэл) цуглуулж авсан мэдээллийг компанийн хариуцсан албанд нь хүлээлгэн өгч нэгтгүүлдэг. Энгийн хяналтын тоонуудыг тодорхой утга илэрхийлэх чадамжтай илэрхийлэл болгож өргөтгөх болон өөрчлөхдөө тохирох хэрэгжилтийн түлхүүр шалгуурын томёоллоор бодож гаргана. Доорхи хүснэгтэнд ХАБЭА-н системийн бүтээмжийг үнэлэхэд чухал шаардлагатай илэрхийллүүдийг багтаасан болно.



германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Implemented by:

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага хөтөлбөр
Integrated Mineral Resource Initiative

Энгийн хяналтын тоо			
Ажиллаагүй ажлын өдөр	DL	Ажлын байрны бүртгэдсэн ослын тоо	RWI
Эмчилүүлэх шаардлагатай гэмтэл	MIT	Тасалдсан ажил	RWC
Тахир дутуу болсон	PTD	Хөдөлмөрийн чадвар хагас алдсан	PPD
Эмчилгээ	MTC	Нээлттэй цаг	EH
Ажилласан цаг	WH		

Энгийн түлхүүр шалгуур үзүүлэлтээр дараах хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүдийг тооцох боломжтой:		
Гэмтэл, бэртлээс болж алдагдсан цаг	LTI	= Осол + PTD + PPD + LWC
LTI-ийн давтагдалт	LTIF	= LTI x 200.000/Нээлттэй цаг
Нийт бүртгэгдсэн гэмтэл	TRIs	= Ослын тоо + LTI + RWI + MTI)
Нийт бүртгэгдсэн тохиолдол	TRC	= LTI + RWC + MTC
Нийт бүртгэгдсэн тохиолдлын давтамж	TRCF	= (LTI + RWC + MTC) x 1,000,000/Нээлттэй цаг
Гэмтэл, бэртийн давтамж	IFR	= Гэмтэлийн тоо * 1,000,000 / ажилласан цаг
Золгүй явдлын давтамж	FFR	= Осол * 1,000,000 / ажилласан цаг
Гэмтэл, бэртлээс болж алдагдсан цаг	LTIFR	= LTIs * 1,000,000 / ажилласан цаг
Тогтмол гэмтэл бэртэл гарах давтамж Гэмтэл, бэртэл	TRIFR	= (Осол + LTIs + RWIs + MTIs) * 1,000,000 / ажилласан цаг
Хүндийн түвшин	SR	= (Алдагдсан өдрийн тоо LTI ба RWI) * 1,000,000 / ажилласан цаг
Үргэлжлэх үзүүлэлт	DR	= (Алдагдсан өдрийн тоо LTI ба RWI) / Ослын тоо + LTIs + RWI)
Ажилд ирээгүй эсхүл алдагдсан ажлын өдрийн тоо	AR LWDR	= Нийт алдагдсан өдрийн тоо * 1,000,000 / ажилласан цаг

Ажилчдын тоо

Нийт ажилчид = жилд ажилласан цаг / 2000
[2000 ж/цаг = 50-н 7 хоног x 40 цагаар жилд
нэг хүний ажлын цагийг ойролцоогорор
бодов

3.5 Хэрэгжилтийг үнэлэх

Хөдөлмөр хамгааллын зохион байгуулалт нь хөдөлмөр эрхлэгчдийн хүсэл зориг, аюулгүй байдал эрүүл мэндийг хамгаалж түүнийг сайжруулах замаар явагдана. Үнэлгээний хэмжүүрийг нэг талаас жишээ нь зорилго, салбарын тэргүүлэгчид эсвэл хувийн стандартуудтай харьцуулсан харьцаагаар үзэж болно. Эсвэл нөгөө өмнөх өөрчлөлтөнд тулгуурласан хөгжлийн үнэлгээ байх боломжтой. Тухайлбал өмнөх жилийнх, жилүүдийн дундаж эсвэл үйлдвэрийн нэгжүүдийн ялгаа г.м.

Зорилгыг ийнхүү тогтмол харьцуулж байх нь компанийн ХАБЭА-н системийг тогтмол сайжруулахад чухал нэгэн хүчин зүйл болдог.



Зураг 12: ХАБЭА-н хэрэгжилтийг тогтмол сайжруулах явц.

KPI-ийн тусламжтайгаар тогтоосон хугацаанд (доод тал нь жилд нэг удаа) ХАБЭА-н системийн бүтээмжүүдэд үнэлгээ өгдөг. Энэ нь ямар арга хэмжээ, хэр хэмжээний хохирол учруулсан, амжилттай нөлөөлсөн үү, ямар нь үгүй вэ гэдгийг

тогтоож, хянан шалгахад хэрэгтэй. Энэ утгаараа бас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд яагаад төлөвлөсний дагуу болоогүй вэ, яаж хэрхэн харилцан зохицож чадах вэ гэх мэт асуудлуудыг тодорхой болох ёстой. Тэгэхлээр үнэлгээ гэдэг нь алдааг дандаа хайх биш бас хэрхэн яаж сайжруулах арга замыг нээж илрүүлэх болон хамгийн боломжийн гарцыг олно гэсэн үг юм. Тийм ч учраас компани бүрийн хувьд ХАБЭА-н тогтолцооны зардлыг бууруулахад туслах үйл явцаар үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагаанд суулгаж өгөх хэрэгтэй.

Тодорхой хүчин зүйл дээр суурилсан ХАБЭА-н системийн нөхцөл байдлыг тодорхойлохын хажуугаар компанийн төлөв байдал, үйл ажиллагаа нь хүссэн ХАБЭА-н системийн арга зүйд нийцэж буй (үйл ажиллагаан дахь оролцоо) эсэхийг аюулгүй ажиллагааны шинжээчдээр эсвэл удирдах албаныхнаар тогтмол явагддаг компанийн шалгалтаар шалгуулах ёстой. Дээр дурьдсан арга хэмжээ, боломжуудын дагуу хэрэв шаардлагатай бол анхаарал татсан хэсэгт төвлөрөх эсвэл төгсгөлд нь үргэлжлүүлээд богино, дэс дараалсан санал бодол сэтгэгдэлээ үлдээх маягаар хөдөлмөрийн үйл явц, аюулгүй байдлын арга зүйн үнэлгээг хийдэг. ХАБЭА-н системийн арга зүй асуудалд мөн ажилчин тус бүрийн чадвар, чадавхийн үнэлгээний тухай нийтийн зөвлөгөөнөөр хэлэлцэх ёстой асуудал юм. Мөн нийт ажилчид өөрийн үүрэг хариуцлагын дагуу бусад хамтран ажиллагсдын, зочдын аюулгүй байдлын хэрэгжилтэнд санаа тавьдаг байх, шаардлагатай тохиолдолд ХАБЭА-н системийн заавар тогтоолд санал оруулах үүрэгтэй.

ХАБЭА-н менежментийн системийн үнэлгээ нь дүгнэлтийн нэг хэсэг нь байх ёстой. Удирдлагын хяналтад (жишээ нь жилдээ нэг удаа) хэрэгцээ шаардлагын зорилтот нийлэмж, үйлчлэл болон бичилт нь системээр болон түүний элементүүдээр дамжиж гүйцэтгэгдэж байхаар баталгаажуулагдана. Энэхүү үнэлгээний явцыг улирал тутам дотоод аудитын үйл ажиллагаагаар дэмжинэ.

3.6 Аудит / хөндлөнгийн хяналт

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй тогтолцоог нэвтрүүлснээр аливаа байгууллагын удирдлагад өөрийн хөдөлмөрийн аюулгүй байдлын хэтийн зорилго болон хэв маягийг ажил хэрэг болгоход хялбар болдог. Хэрэгжүүлсэн системийн үр ашиг, нөлөөллийг аудитын шалгалтыг тогтмол явуулсны хүрээнд мэдэх бөгөөд түүний тусламжтайгаар тэрхүү тогтолцоог үргэлж сайжруулж бэхжүүлэх боломж бий болдог. Аудит нь хөндлөнгийн бусдаас хамааралгүй шалгалт бөгөөд шалгалтыг баримтжуулна. Олон удаагийн аудитад тусгагдсан мэдээллүүдийг харьцуулах замаар үнэлгээ дүгнэлт өгөх боломжтой билээ. Аудитын хамрах хүрээ нь харилцан адилгүй байх бөгөөд тодорхой цаг хугацааг хамарсан байна. Мөн аудитыг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хийлгэж болно.

Аудитын баг нь тухайн аудит хийгдэж байгаа хэсэгт ямар нэгэн ашиг сонирхлын зөрчилгүй, биеэ даасан мэргэжилтнүүдээс бүрдэх ба ахлагчийн удирдлаганд ажилладаг. Аудит урьдчилж бэлтгэсэн хөтөлбөрийн дагуу явагдах ба шалгалтын агуулга, аргачлал, хамрах хүрээ болон зорилго тодорхой байна. Аудитыг хийж дууссаны дараа аудитын тайланг бичиж баримтжуулна.

Аливаа аж ахуйн нэгж нь байгууллагын тодорхой үйл явцад чиглэсэн дотоод аудит/хяналтыг зохион байгуулж болох бөгөөд түүний тусламжтайгаар өөрийн системийн тухайн хамрах хүрээнд үнэлэлт, дүгнэлт хийж, засаж залруулах, сайжруулах боломжийг бүрдүүлдэг давуу талтай.

Тухайн компанийн хэрэглэгчдийн болон ашиг сонирхлын бүлгүүдийн зүгээс, түүнчлэн яам тамгын газрын болон итгэмжлэгч байгууллагын захиалгаар хөндлөнгийн аудитыг хийлгэх эрхтэй байдаг.

ХАБЭА-н системийг хэрэгжүүлснээр тодорхой тогтсон хугацаанд жишээлбэл жилдээ нэг удаа байгууллагыг бүрэн хамарсан дотоод аудит хийгдэнэ. Аудитын дүгнэлтийн дагуу сайжруулах, засах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй бөгөөд байгууллагын бүх шатанд мэдээллийг хүргэж танилцуулах ба мэдээллийг ил тод байлгана.

4 Хураангуй

ХАБЭА нь компанид туслах үйл явцаар ойлгогдох ба тохирох үйл ажиллагаанд холбогдож, үйлдвэрийн аюулгүй байдлыг дээшлүүлж, юуны өмнө компанийн эдийн засгийн болоод өрсөлдөх чадварыг сайжруулдаг.

Ингэхийн тулд үйлдвэрийн дотор зорилго зорилгод тулгуурласан, зохион байгуулалттай, биелэлттэй, хяналт сайтай мөн шаардлагатай тохиолдолд өөрчлөх боломжтой нэгдсэн ХАБЭА-н менежментийн тогтолцоог бий болгох нь чухал юм. Туршлагаас үзвээс хөдөлмөр хамгааллын энэхүү хэлбэр нь менежментийн тусламжтай хэрэгжиж буй хөдөлмөр хамгааллын зохицуулалт нь одоо байгаа бүтцэд нэвтрэн хэрэгжих боломжтойгоороо давуу талтай. ISO серийн стандартууд, тухайлбал 9001 (чанар) эсхүл 140001 (байгаль орчин)-ы дагуух менежментийн системээр нөөцүүдийг хооронд нь холбож харилцан үйлчлэх хуулийн дагуу компанийн олон салбарууд хөгжихийг зорилго болгож болно.

ХАБЭА-ын удирдлагын тогтолцоо нь жишээ нь OHSAS 18001 гэх олон улсын стандартаар гэрчилгээжиж, мөн батламж авах боломжгүй гэдгийг нь хүртэл тогтоож өгдөг. Энэхүү стандарт нь ажлын байрны аюулгүй байдлыг дээшлүүлснээр үйл явцыг илүү уялдуулж өгч, мөн ажлын байрны аюул осолд өртөгдөгчдийн эрүүл мэндийг тогтмол сайжруулах, компанийн үнэ цэнийг өсгөх г.м. зүйлээр тодорхойлогдоно. Түүнчлэн компанийн нийт ажилчид, түншүүдийн

идэвхи чармайлтаар, ХАБЭА-г системтэйгээр хэрэгжүүлснээр амжилтанд хүрэх бүрэн боломжтой.

ХАБЭА-н дэс дараалсан цэгцтэй зохион байгуулалтаас дараах давуу талууд бий болж болно. Үүнд: осол гэмтэл, өвчлөлөөс үүдэлтэй цагийн алдагдал багасах, сэтгэл хангалуун байдал дээшилснээр ажиллагсдын хөдөлмөрийн чадамж дээшлэх г.м. Цаашилбал, төр засгийн байгууллага эсвэл оролцогч талууд, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч г.м. гаднаас тавигдах нөхцөл шаардлагууд нь хялбар байдлаар биелэх боломжтой.

Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхэд тохирох харилцааны хэлбэрийг ашигласнаар компаниудын нэр хүнд сайжирдаг. Энэ нь амжилтанд сэтгэл хангалуун байдлыг авчраад зогсохгүй өрсөлдөх чадварыг дээшлүүлэх ая холбогдолтой. ХАБЭА үүгээрээ компанийн соёлын салшгүй нэг хэсэг болдог юм.

Олон улсын ихэнх компаниуд ХАБЭА-н менежментийн системийн давуу талыг ойлгоод зогсохгүй орчин үеийн байгууллагын удирдлагын зайлшгүй нэгэн хэсэг мөн болохыг хүлээн зөвшөөрч байна. ХАБЭА-н менежментийн тогтолцоо нь таны компанийг зах зээл, үйлчлүүлэгч, төр болоод нийгмийн хэрэгцээ шаардлагуудад нийцэхэд туслах болно.



германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Implemented by:



Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага хөтөлбөр
Integrated Mineral Resource Initiative

5 Холбоо барих



германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Implemented by:



ГОУХАН О.Батболд/Ш.Хансельманн



Gesellschaft für Consulting,
Business und Management mbH

Томас Траппе

Др. инженер
Уул уурхай, ХАБЭА-н мэргэжилтэн

+49 6826 - 51 09 10
 +49 6826 - 52 42 63
 trappe@cbm-ac.de

Ёорг Вийлде

Диплом инженер
Уул уурхай, ХАБЭА-н мэргэжилтэн

+49 241 - 8949 9851
 +49 241 - 8949 8854
 wilde@cbm-ac.de

Яан Шиффер

Ш/У-ы магистр Аюулгүй
байдлын инженер
ХАБЭА-н мэргэжилтэн

+49 241 - 8949 8852
 +49 241 - 8949 8854
 schiffer@cbm-ac.de



CBM компанийн
талаархи дэлгэрэнгүй
мэдээллийг [www.cbm-
ac.com](http://www.cbm-ac.com)¹ хуудаснаас авна
уу.



**ХАБЭА-ын концепц,
нэгдсэн удирдлагын
тогтолцооны талаархи
нэмэлт мэдээллийг
[удирдлагын
тогтолцоо](#)[www.cbm-
ХАБЭА.com](http://www.cbm-
ХАБЭА.com) хуудаснаас
авна уу.**

¹ Смарт утас болон таблет дээрээ qr код скеггер ашиглан нэмэлт мэдээлэл, сэдвийн талаар интернэтээс авч болно.

6 Нэр томъёоны тайлбар толь

Нэр томъёо	Тодорхойлолт
Осол	Осол гэж урьчилан харах аргагүй үйл явдлын хэлхээ бөгөөд нөхцөл байдлаас гэмтэл бэртэл, өвчин / эсхүл хүн, хөрөнгө, байгаль орчинд юм уу нэр хүндэд учрах хохирлыг хэлнэ.
Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа гэж байрлалд эсхүл ажлын байран дахь үүрэг даалгавар, үүрэг оролцоо, гүйцэтгэл эсхүл нөхцөл байдлыг (аливаа ажлын гүйцэтгэлийг оролцуулан ж/нь ажил олгогчоос ажил үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нийлүүлсэн техник, төхөөрөмж ашиглахыг).
AR - Эзгүй байсан хугацаа	AR = Нийт алдагдсан өдрийн тоо * 1,000,000 / ажилласан цаг
Аудит / хөндлөнгийн хяналт	Хувь хүн, байгууллага, тогтолцоо, үйл явц, аж ахуйн нэгж, төсөл эсхүл бүтээгдэхүүний үнэлгээ.
Аудит / хөндлөнгийн хяналт хийх	Байгууллагад тогтоосон шалгуурын хэрэгжилтийн хэмжээг тодорхойлох зорилгоор баримтанд тулгуурлан, үнэн бодитоор системтэйгээр, хөндлөнгөөс үнэлэх бие даасан, баримтжуулсан үйл явц.
Нэгдэл	Ажилчид, гэрээлэгчдийг оролцуулан дотоод нэгдэл болон тухайн орон нутаг, уугуул иргэд, төрийн бус байгууллага, засгийн газар, бизнесийн түнш, үйлчлүүлэгчид, нийлүүлэгчид болон бусад чухал талуудыг оролцуулсан гадаад нэгдлийг хэлнэ. Энэхүү стандартад "нэгдэл" гэсэн нэр томъёог хүний эрхийг харгалзан хүндэтгэж хэрэглэнэ.
Гэрээлэгч	Тохиролцсон хугацаа, нөхцөл байдлын дагуу ажил олгогчид ажил олгогчийн ажлын байранд үйлчилгээ үзүүлэгч хувь хүн буюу байгууллага. Хувь хүн буюу байгууллагын ажил эсхүл чадварыг нь бие даасан гэрээлэгчээр хөлсөлж, бүтээгдэхүүн үйлчилгээг нэхэмжлэлийн дагуу төлнө.
Шүүмжлэлтэй ажилбар	Хүлээгдэж буй үр дүнгүүдээс гадна хүнд хэлбэрийн буюу том осолд хүргэж болохуйц нөхцөлтэй, шүүмжлэлтэй / эгзэгтэй үйл ажиллагаа
Шүүмжлэлт хяналт	Томоохон осол гаргах эрсдлийг багасгах зорилготой хяналтын удирдлага
Эгзэгтэй тоног төхөөрөмж	Хэрэв ажиллахаа боливол томоохон осол гарах нөхцөл үүсгэж мэдэх төхөөрөмж, байгууламжийн нэг хэсэг
Шүүмжлэлтэй горим, үйлдэмж	Томоохон осолд хүргэж болзошгүй үйлдэмж, процедурын (эсхүл үйлдэмжийн нэг шат) гажилт.
Шүүмжлэлтэй тогтолцоо	Ердийн ажиллагаанаас гадна томоохон осолд хүргэж болзошгүй тогтолцоо (тоног төхөөрөмж эсхүл программ хангамж, түүнчлэн хүний хүчин зүйл).
DR - үргэлжлэх хэмжээ	DR = (Алдагдсан өдрийн тоо LTI ба RWI) / Ослын тоо + LTI + RWI)
Ажилчин	Хөдөлмөрийн гэрээ бүхий ажилчин

Ажилчдыг дэмжих хөтөлбөр	Ажлын болон ажил тасалдсан асуудлыг шийдэхэд нууцыг хадгалсан, бодит, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий хөтөлбөр
Байгаль орчин	Тухайн компанийн байршилтай холбоотой түүнийг хүрээлэн буй орчин, үүнд агаар, ус, хөрс, байгалийн нөөц, ургамал, амьтан, амьдрах орчин, түүнчдэн хүний гараар бүтсэн дурсгалт зүйлс, соёлын өв болон нийгмийн харьцаа орно. Энэхүү орчны нөхцөл байдлаасаа гадна байгаль орчин нь даяар системийн нэг бүрдэл болно.
Нээлттэй цаг	“Нээлттэй цаг”-ийг гүйцэтгэлийн тооцоонд хэрэглэх ба энэ нь ажилчин эсхүл гэрээлэгчийн ажил үүргээ гүйцэтгэсэн нийт ажлын цаг болно. Үүнд ажил эхлүүлсэн, ажил дуусгавар болгосон, ажилтай холбоотой албан томилолтын цаг орох ба харин гэрээсээ ажилд ирэх цаг тооцогдохгүй.
Анхан /шатны/ тусламж үзүүлэх	Эмч, сувилагч болон эмнэлгийн ажилтнаар бус, ажлын байран дээр нэн даруй хийлгэх эмчилгээ, бага зэргийн шарх, зулбаралт, түлэгдэлт, нүдэнд жижиг зүйл орсныг эмчилж, ажиглахыг хэлнэ.
Эвдрэлийн модны задлан шинжилгээ	Зохион бүтээлтийн дутагдлын байдал, үр дагаврын задлан шинжилгээ
Золгүй явдал	Гэмтэл авсан болон үхлийн хугацааг тооцохгүйгээр ажилтай холбоотой гэмтлээс болж нас барах.
FFR - Золгүй явдлын давтамж	$FFR = \text{Осол} * 1,000,000 / \text{ажилласан цаг}$
FMECA - зохион бүтээлтийн дутагдлын байдал, үр дагаврын задлан шинжилгээ	Болзошгүй гэмтлийн төрлүүдийг үнэлэх, хэсэгчлэн дүн шинжилгээ хийх, түүнчлэн дээд зэргийн алдагдалд хүргэх боломж нөхцлийг нөлөөллийн магадлалтай харьцуулж гаргахыг хэлнэ. Үйлдвэрийн процесс /урсгал тогтолцоог хянахад хэрэглэгдэнэ. Дүн шинжилгээний үр дүнг аюулгүй ажиллагаа, шүүмжлэлтэй тогтолцоо бий болгоход хэрэглэнэ.
HAZAN - Аюул заналын задлан шинжилгээ	Дараах арга хэмжээ HAZOP-д зориулан HAZAN буюу аюул заналын задлан шинжилгээг хүндрэлтэй асуудал гарах магадлал, түүнээс үүдэх гарч болзошгүй хохирлыг тодорхойлоход хэрэглэдэг.
HAZOP - Аюул заналын болон нөхцөлт боломжийн задлан шинжилгээ	Аюулгүйн ажиллагааны боломж болон үйл ажиллагааны хүндрэлтэй асуудал гарах нөхцлүүдийг зохион бүтээлт, засвар үйлчилгээ эсхүл үйлдвэрлэлийн тогтолцоотой холбоотойгоор илрүүлэх зорилготой боловсруулсан аргачлал. HAZOP албан ёсоор ашиглах ёстой аргачлал бөгөөд аливаа ажлын бүлэг нэг систем/тогтолцооны янз бүрийн хэсгийг сонгон авч тодорхой "зааварчилгаа"-ны дагуу үнэлгээ өгдөг.
Аюул занал	Хүний эрүүл мэндэд гэмтэл буюу хохирол учруулах болзошгүй байдал.

HIRA - Аюул тодорхойлох болон эрсдлийн үнэлгээ	HAZOP-той ойролцоо, зааварчилгааны дагуу аюул заналын шалтгаан, нөлөөллийг тодорхойлдог. Ихэнхдээ техникийн доголдлыг аюул занал үүсэх нөхцөл байдалтай холбож үзэхэд ашигладаг.
HAZID - Аюулыг тодорхойлох	Байгууламж, тогтолцоо эсхүл үйлдвэрт дээд түвшинд системтэйгээр болзошгүй аюул заналын задлан шинжилгээ хийхийг хэлнэ. Энэ аргачлал нь эрсдэлийн удирдлагад эрсдлийн үнэлгээ болж ашиглагдана.
ХАБЭА-н удирдлагын стандарт	ХАБЭА-н удирдлагын тогтолцоог компанийн бүхий л түвшинд нэвтрүүлнэ.
ХАБЭА-н удирдлагын тогтолцоо	Байгууллага үйл явцын үр нөлөө, хэрэгжилтийг хянаж, байгууллагын гүйцэтгэлийн хангалттай байдлыг тодорхойлоход хэрэглэх арга ба өгөгдлийг хэрэглэх удирдлагын тогтолцоотой байна. Үр дүнд байгууллага гүйцэтгэлээ хөтөлж, үйл ажиллагаагаа байнга сайжруулж, ил тод тогтолцоотой болдог. Чанарын удирдлагын тогтолцоо нь сонирхогч бүх талын хэрэгцээ ба хүслийг тэнцвэртэй байдлаар анхаарч үзэх замаар үр нөлөө, үр ашигтай тогтолцоо бий болгох явдлыг хангаж өгдөг
Тохиолдол	Ажил эрхлэх явцад гарсан, хүн бэртэж өртөөгүй, байгаль орчинд хохирол учруулаагүй аюултай тохиолдол
Гэмтэл, бэртэл	Хүмүүс ажил үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэх, бэртэл авах.
IFR - Гэмтэл, бэртлийн давтамж	$IFR = \text{Гэмтлийн тоо} * 1,000,000 / \text{ажилласан цаг}$
JHA – ажлаас үүдсэн аюул заналын задлан шинжилгээ	Ажлын харилцаанаас үүдсэн аюул заналыг тодорхойлох тогтолцоо.
JSA - ажлын аюулгүй байдлын шинжилгээ	Аюул занал болон хяналтын тусгай үнэлгээ. JSA-ийн зорилго нь хүмүүс өдөр бүр ажлын байрандаа ажил үүргээ гүйцэтгэж байхад нь ямар аюул занал байдгийг тодорхойлоход оршино.
KPI - Хэрэгжилтийн түлхүүр шалгуур	Байгууллагын стратегийн болон үйл ажиллагааны зорилтуудын хэрэгжилтийн үр дүн, чанар сайжруулах зорилгоор тодорхой салбарт эсхүл аж ахуйн нэгжид хэрэглэгддэг, харьцуулдаг тоон хэмжигдэхүүнүүд,
LTI - гэмтэл, бэртлээс болж алдагдсан цаг	Ажилчин / гэрээлэгч гэмтэл, бэртэл авсны дараахи календарийн өдрөөс эхлэн ажиллах боломжгүйгээс болж алдагдсан цаг
LWC – алдагдсан ажил	Ажилчин / гэрээлэгч гэмтэл, бэртэл авсны дараахи календарийн өдрөөс эхлэн ажил үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаагаас орхигдсон аливаа ажил
LWD – алдагдсан ажлын өдрүүд	Гэмтэл бэртэл авснаас ажилчин түр хугацаагаар ажиллаагүй нийт хоног

Удирдлагын тогтолцоо	Бодлого зорилгоо тодорхойлох, зорилгодоо хүрэхэд ашиглах, хорондоо уялдаа бүхий элементүүд. Энэ нь байгууллагын зохион байгуулалтын бүдүүвч, үйл ажиллагааны төлөвлөгөө (түүнчлэн эрсдлийн үнэлгээ болон зорилтуудын тодорхойлолт), үүрэг хариуцлагын хуваарилалт, хэрэгжүүлэх аргачлал, горимууд, үйл явц болон нөөц зэрэг болно.
Томоохон осол	Аливаа тохиолдол дараах уршиг үүсгэх магадлалтай байдаг: <ul style="list-style-type: none"> – золгүй явдал – байгал орчинд ноцтой нөлөөлөх, экосистемийн тэнцвэр алдагдуулах нөлөөл үзүүлэх – нийгмийн ноцтой нөлөөлөл – үндэсний олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон төрийн бус байгууллагуудын анхаарлыг татах эсхүл ажиллах лицензээ алдах.
MIT - эмчлүүлсэн гэмтэл	Ажилчин / гэрээлэгч гэмтэл, бэртэл авснаас ажилчныг захиргаан дээр сувилах, эмчлэх, ухаан оруулах болон арчлах, ингэхэд цаг алдаагүй эсхүл ажил зогсоогүй байх
MTC - эмчилгээ	Ухаан алдсанаас үүдэлтэй гэмтэл, бэртлийг эмчлэх бүхий л эмчилгээ (эрүүл мэндтэй холбоотой учир) эсхүл анхан шатны тусламжаас илүү мэргэжлийн тусламж үзүүлэх, эмч, шүдний эмч, мэс засалч эсхүл эмчийн хяналтан дор мэргэжлийн сувилагч санитар ажиллах
Аюултай нөхцөл байдал	Ялимгүй өөрчлөгдсөн нөхцөл байдалд хохирол учруулж, хүнд гэмтэл бэртэл учруулж болзошгүй нөхцөл байдал. Одоогийн нөхцөл байдал нь бодитоор хохирол учруулаагүй, хүнд гэмтэл бэртэл тохиолдоогүйг хэлнэ.
ХАБЭА-ын удирдлагын тогтолцооны систем	Байгууллага өөрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн эрсдлийг удирдах, үр дүнг тогтмол сайжруулдаг байхыг хэлнэ.
Түншүүд	Хувь нийлүүлсэн түншүүд, төсөл хэрэгжүүлэх болон компанийн ажлын хөтөлбөрт оролцогч бусад талууд, гэрээлэгч нар хамаарахгүй.
Боловсон хүчин	Компанид ажиллуулахаар авсан хүмүүс, ажилчид
PPD - Хөдөлмөрийн чадвар хагас алдсан	Ажлаас шалтгаалан гэмтэл, бэртэл авсны улмаас хувь хүн бие эрхтнээ алдах эсхүл биеийн тодорхой хэсэг бүрэн ажиллах чадваргүй болсон ч гэмтэл авсан ажилчин хязгаарлагдмал байдалд тодорхой орчинд удаан хугацаагаар ажиллах боломжтойг хэлнэ.
PPE - Хөдөлмөр хамгааллын багаж	Олон янзын аюул заналаас хамгаалах, багасгах, сэргийлэх зорилготой хэрэгслүүд. PPE-ийн жишээ: ажлын бээлий, хөл, нүдний хамгаалалт, хамгаалалтын хувцас, чихэвч, хамгаалалтын малгай, маск, болон бүрэн хувцас зэрэг болно.

Горим	Зайлшгүй баримтлах үйл ажиллагааны алхам бүрийн дараалал эсхүл үүрэг даалгаврыг нягт гүйцэтгэхэд ижил дараалалттай гүйцэтгэх аргачлал (тодорхой эхлэх болон дуусах цэг/хэмжүртэй).
PTD – бүрэн тахир дутуу	Ажлаас шалтгаалан гэмтэл, бэртэл авсны улмаас хувь хүн бүрэн ажлын чадваргүй болох, ямар нэг байдлаар усанд болон газарт ямар нэг байдлаар ажиллах чадваргүй болохыг хэлнэ. Энэ нь аливаа эрхтэн дутуу болох, хараагүй болох эсхүл тархины гэмтэл байж болно.
Эрсдэл	Аюул занал бүхий тохиолдол гарах, үүнтэй холбоотой хүнд учирч болох гэмтэл, хохирлын болзошгүй хэлбэрийн хослол.
Эрсдлийн үнэлгээ	Ажлын байрны аюул заналаас шалтгаалсан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн эрсдлийг үнэлэх үйл явц.
RWC – тасалдсан ажил	Ажлаас үүдэлтэй гэмтэл, бэртлээс болж ажилчин, гэрээлэгч даалгаварт ажил төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэж чадахгүй байх эсхүл тодорхой хугацаагаар гэмтэл авсан өдрөөс эхлэн өөр ажилд томилогдон ажиллах
RWI – ажлаас үүдсэн гэмтэл	Ажлаас үүдэлтэй гэмтэл, бэртлээс болж ажилчин, гэрээлэгч гэмтэл авснаас хойш ажлаа үүргээ гүйцэтгэж чадаагүй бүтэн өдөр.
RWD – ажиллаагүй өдөр	Ажлаас үүдэлтэй гэмтэл, бэртлээс болж ажилчин ажиллаагүй календарийн өдрөөс эхлэн ажилдаа эргэн орсон өдөр хүртэлх нийт хоног
Аюулгүй ажиллагаа	Хүн, тоног төхөөрөмж эсхүл хөрөнгөд гэмтэл эсхүл алдагдал учруулахгүй нөхцөл байдал
Шүүмжлэлтэй ажилбар	Ямар ч үйл ажиллагаагаар хяналт л байхгүй бол хүн хүндээр гэмтэх, бэртэх аюул байнга дагалдаж байдаг.
Аюулгүй ажиллагаанд шүүмж өгөх үүрэг	Түлхүүр үүрэг, хариуцлага бүхий хүн нь ядаж наад зах нь нэг удаа аюулгүй ажиллагааны тогтолцоо эсхүл хяналтын талаар шүүмж санал өгдөг байна.
Өөрийн үнэлгээ	Үйл ажиллагаанд компаниас гаргасан журам, стандартыг баримталж буйг, хэрэгжүүлж, үр нөлөөтэй байгааг батлах дотоод хяналтын систем, горим, мэдээлэл, дадал эсхүл аргачлал.
SR - Хүндийн түвшин	$SR = (\text{Алдагдсан өдрийн тоо LTI болон RWI}) * 1,000,000 / \text{ажилласан цаг}$
Үйлдвэрийн талбар	ХАБЭА-н хэрэгжилтийг хэмжих, мэдэгдэх, хариуцсан үйлдвэрийн эзэн/даргын зүгээс тодорхой арга хэмжээ авч болохуйц ажлын байр эсхүл бизнесийн нэгж. Энэ нь тодорхой (газар дээр, усан дээр эсхүл тээврийн хэрэгслэл болон бусад ямар ч орчин байж болно) хөдөлгөөнт, түр зүүурын эсхүл өөр байдлаар ажил үүрэг гүйцэтгэх тодорхой газар байж болно.
Үйлдвэрлэлийн удирдлага	Менежмент болон арга хэмжээ, үйл ажиллагаа, төсөл эсхүл эрсдэлтэй ажлыг бүхэлд нь хянадаг хүн

SOP - ажлын зааварчилгаа	Их, бага эрсдэлтэй тодорхой ажил үүргийг алхам алхамаар гүйцэтгэх тухай бичиглэсэн зааварчилгаа. SOP-д үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, засвар эсхүл ажлын төрлүүдэд зориулсан нилээн хэдэн зааварчилгааг нэгтгэсэн байж болно. SOP-ыг тодорхой ажил үүргийг нэг л горимоор жигд хийж гүйцэтгэхэд ашиглах зорилготой. SOP нь тодорхой ажлын алхамуудад JSA-г боловсронгуй болгохтой холбоотойгор аюул заналыг илрүүлэхэд ашиглана.
SWP - Аюулгүй ажиллагааны дадал	Тодорхой ажил үүргийг аюулгүй, баталгаатай гүйцэтгэхэд хэрэглэгдэх нэг л зүйлд зориулагдсан процедур. SWP-д өндөр зэрэглэлийн эрсдэлтэй ажлуудыг авч үздэг. ажлын баталгаатай байдлыг ханган зохицуулахад SWP-г хэрэглэнэ.
Хэрэгслүүд	ХААЭА-ны удирдлагын стандарт, түүнтэй холбоотой гарсан заавар дүрмүүдийг мөрдөхөд практик ач холбогдол бүхий үйл ажиллагааны заавар, зааварчилгаа, хяналтын хуудас, маягтууд болон бусад баримтууд
TRC - Нийт бүртгэгдсэн тохиолдол	$TRC = LTI + RWC + MTC$
TRCF – Нийт бүртгэгдсэн тохиолдлын давтамж	$TRCF = (LTI + RWC + MTC) \times 1,000,000 / \text{Нээлттэй цаг}$
TRI – нийт бүртгэгдсэн гэмтэл	$TRI = \text{Ослын тоо} + \text{Гэмтлээс үүдсэн цагийн алдагдал} + \text{Гэмтлээс үүдсэн ажлын алдагдал} + \text{Гэмтлээс үүдсэн эмчилгээ}$
Тогтмол гэмтэл бэртэл гарах давтамж (TRIFR)	Гэмтэл, бэртэл тохиолдох давтамжийн нийт тоо
Эрсдэлтэй үйлдэл	Алдаатай үйлдэл эсхүл ажиллагаа, эсхүл хувь хүн дүрэм журам зөрчсөн үйлдэл гаргаснаас үүдэлтэй хортой эсхүл хүсээгүй тохиолдол эсхүл сөрөг үр дагавар гарах
Эрсдэлтэй нөхцөл	Болгоомжгүй байдлаас шалтгаалан хүний биед, заримдаа байгаль орчноос нөлөөлж болохуйц нөхцөл байдал. Гэхдээ хортой нөхцөлд тооцогдохгүй эсхүл гажууд нөлөө үзүүлэхгүй.
Зочин	Компанийн ажилтан биш, гэрээлэгч биш, компани/үйлдвэр үзэхээр ирсэн хүн.


7 Зураг зүй

ЗУРАГ 1 ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН УДИРДЛАГЫН ДАВУУ ТАЛУУД	10
ЗУРАГ 2: КОМПАНИЙН ХАРИЛЦАГЧ ТАЛУУД	11
ЗУРАГ 3: ЦОГЦ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО	12
ЗУРАГ 4: ХАБЭА-Н ЗУРАГЛАЛ	13
ЗУРАГ 5: (АЛТАН СУДАЛ) ГОЛЛОХ ҮЙЛ ЯВЦЫН ҮНЭЛГЭЭНД ХАБЭА-Н НӨЛӨӨЛӨЛ.....	17
ЗУРАГ 6: ХЯНАЛТ	19
ЗУРАГ 7: ХАБЭА-Н УДИРДЛАГЫН СИСТЕМИЙН ЭЛЕМЕНТҮҮД	20
ЗУРАГ 8: УХААЛАГ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	22
ЗУРАГ 9: ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ.....	23
ЗУРАГ 10: ЭРСДЛИЙН ТҮВШИН, ТӨРӨЛ	24
ЗУРАГ 11: НӨЛӨӨЛЛИЙГ ХЭМЖИХ ШАТЛАЛ.....	25
ЗУРАГ 12: АЖИЛЧДЫН ЭРҮҮЛ МЭНДЭД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД.....	27
ЗУРАГ 13: ОСЛЫН ПИРАМИД.....	29
ЗУРАГ 14: ОСОЛ ГЭМТЭЛ, ОСОЛД ӨРТӨХ НӨХЦӨЛ, ТОХИОЛДЛЫГ МЭДЭГДЭХ, БҮРТГЭХ ..	29
ЗУРАГ 15: НӨЛӨӨЛӨЛ ШАЛТГААНЫ УЯЛДАА	30
ЗУРАГ 16: ШАЛТГААНЫГ ЗУРАГЛАХ АРГАЧЛАЛЫН ҮНДСЭН 3 АЛХАМ	30
ЗУРАГ 17: ЭРҮҮЛ АХУЙН ХАМГААЛЛЫН ТЭМДЭГЛЭГЭЭНҮҮД	32
ЗУРАГ 18: ОНЦГОЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ЗОХИОХОД ГАРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД..	36
ЗУРАГ 19: ЗОРИЛТУУДАД ХҮРСЭН ҮР ДҮНГ ХАРЬЦУУЛАХ	37
ЗУРАГ 20: ЖИШЭЭЛСЭН АЛБАН ТУШААЛЫН ШАТЛАЛ.....	42
ЗУРАГ 21: МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОО	44
ЗУРАГ 22: ХАБЭА-ЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТОГТМОЛ САЙЖРУУЛАХ ЯВЦ.	47

8 Хавсралт

- 8.1 Эрсдлийн үнэлгээний загвар
- 8.2 Компани дахь хөдөлмөр хамгааллын багаж ашиглалт
- 8.3 Компанийн гэрээлэгчид хөдөлмөр хамгааллын багаж ашиглах нь
- 8.4 ХАБЭА-н шалгалт
- 8.5 Ослыг мэдэгдэх явц
- 8.6 Шалтгаан ба үр дагаврын дүн шинжилгээ, загасан ясны зураглал
- 8.7 Гэнэтийн аваар ослын үед ашиглах төлөвлөгөө
- 8.8 Дотоод төлөвлөгөөний зааварчилгаа: Ослын удирдлага
- 8.9 Дотоод зааварчилгаа: Галын аюулын үед авах арга хэмжээ
- 8.10 Дотоод төлөвлөгөөний зааварчилгаа: цахилгаан хүчдэлтэй үйлдвэр болон тоног төхөөрөмж дээр ажиллах нь
- 8.11 Дотоод төлөвлөгөөний зааварчилгаа: хортой бодис
- 8.12 Сүүлийн мөч дэх эрсдлийн үнэлгээний загвар (СМЭҮ)
- 8.13 Хөдөлмөр эрхлэлтийн зөвшөөрлийн маяг

8.1 Эрсдлийн үнэлгээний загвар



Магадлал

Түвшин	Ангилал	Тодорхойлолт	1:100.000	< 3 %
1	Ховор	Зөвхөн онцгой нөхцөл байдалд	1:10.000	3 - 10 %
2	Бараг үгүй	Хааяа тохиолдох магадлалтай	1:1.000	10 - 50 %
3	Магадгүй	Хааяа тохиолдох магадлалтай	1:100	50 - 90 %
4	Бараг	Ихэнх нөхцөлд гарах магадлал өндөр	1:10	> 90 %
5	Баталгаатай	Ихэнх нөхцөл байдалд тохиолдоно		

Аюулын зэрэглэл

Түвшин	Ангилал	Тодорхойлолт	Бодит жишээ:
А	Бага гэмтэл / Нөлөөлөлгүй	Эл ослын үед бага зэргийн гэмтэл, өвчлөл тохиолдох ба болон анхны тусламж шаардлагатай. Ажилчин ажлаа үргэлжлүүлэн хийнэ.	Бага зэргийн шарх, түлэгдэлт, толгой өвдөх
Б	Дунд зэргийн / Аюултай	Эл аюул нь ослын шинжтэй бөгөөд ажилчин 1-с 14 хоног ажлаас чөлөөлөгдөнө.	Шагай тулгарах, зөөлөн эд гэмтэх, ханиад томуу
В	Хохирлын уршиггүй	Эл аюул нь ослын шинжтэй бөгөөд ажилчин 15 болон түүнээс дээш хоног ажлаас чөлөөлөгдөнө. Түр зуурын шинжтэй гэмтэл.	Хөл хугарах
Г	Хохиролтой	Эл аюулын улмаас нэг болон түүнээс олон эрхтэний хүнд гэмтэл, өвчлөл эсхүл ажиллах чадвараа алдана. Нөхөж эдгэрэх боломжгүй гэмтэл.	Хөлгүй болох, биеийн эд эрхтэн гэмтэх
Д	Амь насанд халтай	Амь насанд хохирол учруулах аюултай.	Амиа алдах, тоосжилтоос үүдэлтэй уушигны хавдар

Эрсдлийн матрикс

		Аюулын зэрэглэл				
		Бага гэмтэл/ Нөлөөлөлгүй А	Дунд зэргийн/ Аюултай Б	Хохирлын уршиггүй В	Г Хохиролтой	Амь насанд аюултай Д
Магадлал	Ховор 1	Хэт бага	Хэт бага	Хэт бага	Багавтар	Дунд зэрэг
	Бараг үгүй 2	Маш бага	Багавтар	Багавтар	Дунд зэрэг	Их
	Магадгүй 3	Багавтар	Багавтар	Дунд зэрэг	Их	Маш их
	Бараг 4	Дунд зэрэг	Дунд зэрэг	Их	Маш их	Хэт их
	Баталгаатай 5	Дунд зэрэг	Их	Маш их	Хэт их	Хэт их

Хөдөлмөр эрхлэлтийн эрсдлийн үнэлгээ (ХЭЭҮ)

Уурхай / Үйлдвэр: _____

Бизнесийн нэгж: _____


Ажлын тодорхойлолт / Үүрэг:

Тоног төхөөрөмж: _____


Хэн *Нэр* *Гарын үсэг* *Огноо*
боловсруулсан: _____
хянасан: _____
зөвшөөрсөн: _____

№г.	Ажлын үүрэг / Алхмууд	Аюул, ачаалал	Аюулын зэрэглэл	Магадлал	Эрсдэл	Хамгааллын бодлого	Аюул, ослыг бууруулах арга хэмжээ	Хариуцсан ажилтан: (нэр, огноо)	Хянасан (огноо)

8.2 Компани дахь хөдөлмөр хамгааллын багаж ашиглалт



8.3 Компанийн гэрээлэгчид хөдөлмөр хамгааллын багаж ашиглах нь



8.4 ХАБЭА-н шалгалт

Дугаар	Тайлбар
НМЕ 1	ашигт малтмалын тоос: силикон тоос, асбестын тоос, хиймэл ашигт малтмалын ширхэгтийн тоос
НМЕ 2	тоосонд өртөх аюултай
НМЕ 3	хар тугалга ба түүний бүрэлдэхүүн (алкилын хар тугалгаас бусад нь)
НМЕ 4	алкилын хар тугалга
НМЕ 5	арьсны өмөн үү үүсгэгч хортой бодисууд
НМЕ 6	гликолын динитрат эсхүл ог глицерины тринитрат
НМЕ 7	нүүрстөрөгчийн дисульфид
НМЕ 8	нүүрстөрөгчийн исэл
НМЕ 9	бензин
НМЕ 10	мөнгөн ус ба түүний бүрэлдэхүүн
НМЕ 11	метанол
НМЕ 12	устөрөгчийн сульфид
НМЕ 13	фосфор
НМЕ 14	трихлорэтен (трихлорэтилен) болоэн бусад хлоржуулсан нүүрсустөрөгчийн уусмал
НМЕ 15	хромын (VI) бүрэлдэхүүн
НМЕ 16	хүнцэл ба түүний бүрэлдэхүүн
НМЕ 17	дeдиметилформадид
НМЕ 18	дуу чимээ
НМЕ 19	хүйтэн нөхцөлд ажиллах
НМЕ 20	хүчлээс үүдэлтэй шүдний өвчлөл
НМЕ 21	агаарын замын өвчин

НМЕ 22	арьсны өвчлөл (арьсны өмөн үүгээс бусад)
НМЕ 23	ажил үүргийг хэрэгжүүлэх, зохицуулан удирлах болон үнэлгээ хийх
НМЕ 24	амьсгалын замын багаж хэрэгсэл
НМЕ 25	айсоцианит
НМЕ 26	толуол ба ксилол
НМЕ 27	халуун орчинд ажиллах
НМЕ 28	хэт хүчтэй даралт
НМЕ 29	кадми ба түүний бүрэлдэхүүн
НМЕ 30	анхилам нитро ба амины хүчлийн бүрэлдэхүүн
НМЕ 31	фтор ба түүний органик бус бүрэлдэхүүн
НМЕ 32	гадаадад ажиллах
НМЕ 33	хлорт винил
НМЕ 34	VDU буюу дэлгэцний ажил
НМЕ 35	никель ба түүний бүрэлдэхүүн
НМЕ 36	гагнуурын утаа
НМЕ 37	сөмөн үү болон мутаци үүсгэх аюултай материал
НМЕ 38	унах аюултай ажил эрхлэх
НМЕ 39	халдвар авах аюулд ажиллах
НМЕ 40	хатуу модны тоос
НМЕ 41	стирол
НМЕ 42	шөрмөс болон биеийн системийн суналт (вибраци буюу чичирхийлэл орно)

8.5 Ослыг мэдэгдэх явц

Аливаа ажлын аваар ослын үед бүх ажиллагсад дараагийн зааварчилгааны дагуу үйл явцыг мэдээлэн мэдэгдэж болно:

Ажилчин гарсан ослын тухай ахлагчид мэдэгдэнэ. Ахлагч болсон үйл явдлын талаар тусгайлан гаргасан аваар ослын дэвтэрт бүртгэнэ. Энэхүү “ослын тайлан” нэртэй албаны бичиг баримтыг бөглөж, компанийн Осол Шинжлэх Хороонд (ОШХ) хүргүүлнэ. Уг хороо нь аваар осолд дүн шинжилгээ хийж, ажил тасалдсан толиолдол нь тухайн аваар осолтой хамаатай эсэхэд дүгнэлт хийнэ. Түүнчлэн тус хороо нь компанийн удирдлагад гарсан ослын тухай заавал мэдэгдэх үүрэгтэй.

Үүний дараа хорооны гишүүд тайлантай танилцаж, гарын үсгээ зурж доор дурдсан албан газар, хүмүүст хүргүүлнэ:

- Ослын тайлангийн нэг хувийг ажилчны ар гэр, хамаатан саданд
- Ослын тайлангийн нэг хувийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хариуцсан мэргэжилтэнд
- Ослын тайлангийн нэг хувийг Нийгмийн хамгааллын албанд
- Ослын тайлангийн нэг хувийг компанийн Хөдөлмөр хяналтын комисст
- Ослын тайлангийн нэг хувийг компанийн удирдлагад
- Ослын тайлангийн нэг хувийг ажилчны хувийн хэрэгт хавсаргана

Осолд хийсэн дотоод хяналтын үр дүнд ажлын байртай холбоотой эрсдлийн үнэлгээг аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, менежерийн хамт шалгана. Энэхүү хянан шалгалтын дараа аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, менежер хоёр урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлно.


Ахлагчид энэ тухай биечлэн мэдэгдэж, ажилчдад зохистой зөвөлгөөг хүргүүлэх хэрэгтэй. Ингэснээр бусад ажилчдад тохиолдсон ослын эрсдлийг дахин дүрслэн, сануулах зохимжтой болно.

Зарим нэгэн чухал, ганцаарчилсан тохиолдолд ХАБЭА-н хэлтсээс мэдээллийн хуудсыг бэлтгэж, компанийн удирдлагад танилцуулж, батлуулахын тулд хүргүүлдэг. Эцэст нь эдгээр хуудас, маягтыг хэлтсүүдэд тарааж өгч, харагдах газар өлгүүлнэ.

8.6 Шалтгаан ба үр дагаврын дүн шинжилгээ, загасан ясны зураглал

1. Шалтгаан ба үр дагаврын зураглалыг зурж & гол нөлөөлөх хувьсагч зүйлсийг өнөөгийн байдлаар бичнэ (хүн, машин, байгаль орчин, материал, аргачлал, арга хэмжээ).
2. Анхдагч болон хоёрдогч шалтгааныг тогтоох.
3. Зураглалыг гүйцээж бүрэн болгох.
4. Магадлалыг тогтооно; үр үр дагаврын шалтгааныг ач холбогдлоор нь ангилна (осол, гарах дөхсөн аваар осол эсхүл аливаа аюул занал бүхий нөхцөл байдал).
5. Таамаг дэвшүүлсэн шалтгааны хэр оновчтойг дахин шалгаж үзэх.

Ишикавагийн зохиосон шалтгаан ба үр дагаврын зураглалын жишээ:




Зураглалын орчуулга:

Шалтгаан		Үр дагавар
Хүн	Машин	Байгаль орчин
Гол шалтгаан		
Хоёрдогч шалтгаан		
Материал	Аргачлал	Арга хэмжээ

Нийт зургаан гол шалтгаанд хуваадаг. Үүнд дараах ангиллаар ялгана:

- Хүний нөөц, ажилтан
 - Ажил эрхлэгчийн мэргэшсэн байдал?
 - Ажил эрхлэгчийн ажилд хандсан урам зориг?
 - Биеийн болон сэтгэл зүйн байдал (ядарсан, өвчтэй...)?
 - ...?
- Машин
 - Техникийн байдал (орчин үеийн аюулгүй байдлын хамгааллын урьдчилсан арга хэмжээг оруулан...)?
 - Зөв ажилладаг эсэх?
 - ...
- Байгаль орчин
 - Тоос, утаа г.м бохирдуулагч...?
 - Дуу чимээ?
 - Халуун/Хүйтэн?
 - Бохир /Замбараагүй?
 - ...
- Материал
 - Материалын доголдол (материалын чанар)?
 - Бүтэц (иртэй, хурц үзүүртэй...)?
 - ...
- Аргачлал
 - Стандарт үйл ажиллагаа?
 - Шаардлагагүй боловсруулах алхмууд?
 - ...
- Удирдлага
 - Буруу / ахлагчийн зааварчилгаа дутуу / харилцагч?
 - ...

8.7 Гэнэтийн аварар ослын үед ашиглах төлөвлөгөө



8.8 Дотоод төлөвлөгөөний зааварчилгаа: Ослын удирдлага

Огноо: 30.09.2013

Дугаар: 1

Онцгой байдлын дугаар


Ослын удирдлага

Тайван бай

Ослын тухай мэдэгд



Эхний хариулагч: _____



- **Юу** болсон бэ?
- **Хаана** энэ зүйл тохилдов?
- **Хэдэн** хүн гэмтсэн?
- **Ямар** төрлийн гэмтэл авсан?
- **Хүлээх** – тодруулах асуултыг!

Анхны тусламж




- Аваар ослын газрыг хамгаалалтад оруулах
- Гэмтсэн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх
- Зааварчилгааг дагах

Түргэн тусламж: _____




Эмч: _____




Дараагийн алхам

- Гал командад мэдэгдэх


Аюулгүй байдлын зохицуулагч _____



Аюулгүй байдлын мэргэжилтэн _____



Компанийн эмч _____



8.9 Дотоод төлөвлөгөөний зааварчилгаа: Галын аюулын үед авах арга хэмжээ

Огноо: 30.09.2013

Дугаар: 2

Галын аюулын үед үйлдвэрт хэрэгжүүлэх төлөвлөгөө

Тайван бай



Залга:
101

Гал гарч байх үед мэдээлэх нь:

- **Хаана** гал гарч байна?
- **Юу** болсон бэ?
- **Хэр** их гал гарч байна?
- **Хэдэн** хүн аюулын байдалд байна?
- **Хэдэн** хүн гэмтсэн?
- **Ямар** гэмтэл авсан?
- **Хэн** мэдээлэл хүргэж байна?
- **Хүлээ-** тодруулах асуултыг!



Залга:
103



Галын
түгшүүр

Аюулгүй газар луу дайжих

Гал унтраах оролдлого

Аюулд буй хүмүүст анхааруулга өг

Өөрийнхөө аюулгүй байдлыг шалга

Гэмтсэн хүнийг халамжил

Гал сөнөөгч хэрэглэ

Хаалгаа хаа, бүү түгж

Сумтай газраар яв

Цахилгаан шат бүү ашигла

Тогтсон цуглах цэг дээр цугларна уу









Дараагийн арга хэмжээ:

- Гал командад мэдэгд
- Түргэн тусламжид мэдэгд
- Хөндлөнгийн ажиглагч байлгахгүй



8.10 Дотоод төлөвлөгөөний зааварчилгаа: цахилгаан хүчдэлтэй үйлдвэр болон тоног төхөөрөмж дээр ажиллах нь

Огноо: 30.09.2013	Цахилгаан хүчдэлтэй үйлдвэр болон тоног төхөөрөмж дээр ажиллах нь	
Дугаар: 1		
Компани:		
Ажлын талбар: Хөдөлгүүрийн хэлтэс	Ажлын байр: Конвейор хөдөлгүүр	
Хариуцсан ажилтан: _____	Даалгавар: Засах	
Гарын үсэг Хэрэглэх талбар		
Цахилгаан хүчдэлтэй үйлдвэр, тоног төхөөрөмж дээр мэргэжлийн хүн ажиллуулна		
Анхаар:	Цахилгаан хүчдэлтэй үйлдвэр, тоног төхөөрөмж дээр зөвхөн тусгай зөвшөөрлийн дагуу ажиллана. Үүнд гэрээлэгч эсхүл аюулгүй байдлын мэргэжилтэн тусгайлан шалгалт хийсэн байна.	
Хүн болон байгаль орчинд учрах аюул		
<ul style="list-style-type: none"> • Өндөр хүчдэл хүний биенд цочирдол, зүрхний саатал, зүрх зогсолт болон ноцтой дотоод гэмтэл учруулах аюултай • Хамгаалалтын хэрэгсэл earth leakage ба тогонд цохиулсаны улмаас түлэгдэх • Авирдаг шат болон бусад өндөр газар ажиллах үед өндрөөс унах аюултай 	 	
Аюулгүй байдал ба сахилга батын дүрэм		
<ul style="list-style-type: none"> • Өндөр хүчдэл тусгаарлагч бээлий болон бусад хамгаалалтын бүх багаж төхөөрө гэмтэл байгаа эсэхийг хэрэглэхээс өмнө сайтар шалгаж үзнэ • Нүүрний хамгаалалт болон тусгаарлагчтай бээлий өмсөнө • Өөрийн зогсож байгаа газраа тогноос тусгаарла • Ойролцоох өндөр хүчдэлтэй хэсгүүдийг бүтээх • Зөвхөн тусгаарлагчтай багаж хэрэглэнэ • Уушги зүрхний сэхээний эмчийг байх үед ажлаа эхлүүлэн хийх 	 	
Аюулын үед хэрэгжүүлбэл зохистой арга хэмжээ		
Хэрвээ багаж хэрэгсэл, түүний бүрэлдэхүүн унасан тохиолдолд:		
<ul style="list-style-type: none"> • Ажлаа зогсоож, цахилгааныг системээс салгах эсэхийг шалгана • Түр саатах тохиолдолд цахилгаан хангамжийг хааж, хүчдэл байгаа эсэхийг шалгаж, гэнэтийн цахилгаан холболтоос хамгаална • Унасан багаж, тоног төхөөрөмжийг авна 		
Анхны тусламж		
<ul style="list-style-type: none"> • Системийг цахилгаан хангамжаас тусгаарлана • Гэмтсэн хүнийг аврана • Анхны тусламж үзүүлнэ (Түлэгдэлтийг хүйтэн усаар, хохирогч амьсгал авахгүй уушги зүрхний сэхээний бүрэн арга хэмжээ авна) • Онцгой Байдлын Албаны Утас Рүү Залга _____ 		
Техникийн үйлчилгээ		
<ul style="list-style-type: none"> • Хэрэглэхээсээ өмнө Та өөрийн хамгаалалтын хэрэгсэл, тусгаарлагчтай ажлын багажаа дахин шалгана уу • Тусгаарлагч бүхий багаж хэрэгслээ хуурай, цэвэрхэн хадгална уу 		

8.11 Дотоод төлөвлөгөөний зааварчилгаа: хортой бодис

Огноо: 30.09.2013

Дугаар: 1

Хортой бодистой ажиллах үйлдвэрийн дотоод зааварчилгаа

Компани:

Ажлын талбар: Лак үйлдвэрлэл

Ажлын байр: Уусгагч

Хариуцах хүн: _____

Гарын үсэг

Даалгавар: Түүхий эдийн оруулга

Хортой материалын тодорхойлолт

Давирхай уусгах Х 50

Хүн болон байгаль орчинд учрах аюул



- Шатамхай шингэн ба and ууршдаг
- Арьс цочроодог
- Нүдэнд орвоос ноцтой гэмтэл учруулна
- Арьсыг харшилтай болгох магадлалтай
- Урагт аюултай
- Усанд хортой бөгөөд урт хугацааны нөлөөлөлтэй



Бүтээгдэхүүний агуулгад: Бисфенол-А-Эпихлоргидрин давирхай (дундаж молекулын жин ≤ 700), Methylbenzol

Аюулгүй байдал ба сахилга батын дүрэм

- Ажлын байрыг сайтар агааржуулж, салхилуулах
- Ажлын байр болон агуулхад тамхи татах, идэж уух хориотой
- Ил гал дээр бодисыг хэзээ ч бүү хатаа



Хамгааллын зөв хувцас: Хамгаалалтын цув эсхүл хормогч, Хамгаалалтын бээлий эсхүл нүүрний хамгаалалт, хамгаалалтын бээлий...



Аюулын үед

- **Гал гарсан үед:** Үйлдвэрийн зааварчилгааг дагана
- Бага зэргийн галыг CO₂ Эсхүл гал сөнөөгч нунгтаар, шаардлагатай бол усаар унтраана
- Шингэн алдалтын үед ахлагч юм уу үйлдвэрийн менежерт мэдэгдэнэ
- **Ослын үед ярих утас:** _____



Анхны тусламж



- **Арьс:** Саван, усаар хордсон хэсгийг сайтар угаана
- **Нүд:** Нүдээ усаар хэдэн минут сайтар зайл
- **Амьсгал:** Агаарт гар. Амьсгал авахгүй тохиолдолд хиймэл амьсгал хийнэ

Хог хаягдлыг зөв аргаар зайлуулах

- Шингэнийг соруулж, хэсэгчил
- Хортой хогийг зайлуулахын тулд хариуцах газарт хаалттай чингэлэгт хийж өгнө

8. 12 Сүүлийн мөч дэх эрсдлийн үнэлгээний загвар (СМЭҮ)

Сүүлийн мөч дэх эрсдлийн үнэлгээний дүн шинжилгээ

Байршил _____ **СМЭҮ**

Даалгавар _____ Т/Ү/Т-ий

Ажлын зөвшөөрлийн дугаар _____ Т/Ү/Т-ий

Огноо _____ Т/Ү/Т-ий

1. Та ажлын зөвшөөрлийн агуулгыг мэдэх үү? Зааварчилгааг дагадаг үү? Т/Ү/Т-ий
2. Ажлын байраа цэвэрлэсэн үү? Т/Ү/Т-ий
3. Аваарын гарц, гал унтраах нэгж, галаас сэргэмжилсэн хэрэгсэл, SOS-ын утас, аюул telephones, аюулын үед ашиглах шүршүүр, түгшүрийн дохиог хаанаас олохыг Та мэдэх үү? Т/Ү/Т-ий
4. Танай систем зөв хамгаалалттай эсэхийг шалгасан үү? Т/Ү/Т-ий
5. Шене ажиллахад аюулгүй юу? Т/Ү/Т-ий

Замын хөдөлгөөн ба аюулгүй явган замыг хүндэлнэ үү!

Анхаар! Та ажлаа эхлүүлэхээс өмнө эдгээр асуулуудад "Тийм-Т", "Үгүй-Ү", "Тохиромжгүй-ТҮ" гэж хариулна уу. Эсхүл ахлагчтай холбогдож, дараагийн арга хэмжээг авна уу.

Сүүлийн мөч дэх эрсдлийн үнэлгээний дүн шинжилгээ

Байршил _____ **СМЭҮ**

Даалгавар _____ Т/Ү/Т-ий

Ажлын зөвшөөрлийн дугаар _____ Т/Ү/Т-ий

Огноо _____ Т/Ү/Т-ий

1. Та ажлын зөвшөөрлийн агуулгыг мэдэх үү? Зааварчилгааг дагадаг үү? Т/Ү/Т-ий
2. Ажлын байраа цэвэрлэсэн үү? Т/Ү/Т-ий
3. Аваарын гарц, гал унтраах нэгж, галаас сэргэмжилсэн хэрэгсэл, SOS-ын утас, аюул telephones, аюулын үед ашиглах шүршүүр, түгшүрийн дохиог хаанаас олохыг Та мэдэх үү? Т/Ү/Т-ий
4. Танай систем зөв хамгаалалттай эсэхийг шалгасан үү? Т/Ү/Т-ий
5. Шене ажиллахад аюулгүй юу? Т/Ү/Т-ий

Замын хөдөлгөөн ба аюулгүй явган замыг хүндэлнэ үү!

Анхаар! Та ажлаа эхлүүлэхээс өмнө эдгээр асуулуудад "Тийм-Т", "Үгүй-Ү", "Тохиромжгүй-ТҮ" гэж хариулна уу. Эсхүл ахлагчтай холбогдож, дараагийн арга хэмжээг авна уу.

Сүүлийн мөч дэх эрсдлийн үнэлгээний дүн шинжилгээ

Байршил _____ **СМЭҮ**

Даалгавар _____ Т/Ү/Т-ий

Ажлын зөвшөөрлийн дугаар _____ Т/Ү/Т-ий

Огноо _____ Т/Ү/Т-ий

1. Та ажлын зөвшөөрлийн агуулгыг мэдэх үү? Зааварчилгааг дагадаг үү? Т/Ү/Т-ий
2. Ажлын байраа цэвэрлэсэн үү? Т/Ү/Т-ий
3. Аваарын гарц, гал унтраах нэгж, галаас сэргэмжилсэн хэрэгсэл, SOS-ын утас, аюул telephones, аюулын үед ашиглах шүршүүр, түгшүрийн дохиог хаанаас олохыг Та мэдэх үү? Т/Ү/Т-ий
4. Танай систем зөв хамгаалалттай эсэхийг шалгасан үү? Т/Ү/Т-ий
5. Шене ажиллахад аюулгүй юу? Т/Ү/Т-ий

Замын хөдөлгөөн ба аюулгүй явган замыг хүндэлнэ үү!

Анхаар! Та ажлаа эхлүүлэхээс өмнө эдгээр асуулуудад "Тийм-Т", "Үгүй-Ү", "Тохиромжгүй-ТҮ" гэж хариулна уу. Эсхүл ахлагчтай холбогдож, дараагийн арга хэмжээг авна уу.

Сүүлийн мөч дэх эрсдлийн үнэлгээний дүн шинжилгээ

Байршил _____ **СМЭҮ**

Даалгавар _____ Т/Ү/Т-ий

Ажлын зөвшөөрлийн дугаар _____ Т/Ү/Т-ий

Огноо _____ Т/Ү/Т-ий

1. Та ажлын зөвшөөрлийн агуулгыг мэдэх үү? Зааварчилгааг дагадаг үү? Т/Ү/Т-ий
2. Ажлын байраа цэвэрлэсэн үү? Т/Ү/Т-ий
3. Аваарын гарц, гал унтраах нэгж, галаас сэргэмжилсэн хэрэгсэл, SOS-ын утас, аюул telephones, аюулын үед ашиглах шүршүүр, түгшүрийн дохиог хаанаас олохыг Та мэдэх үү? Т/Ү/Т-ий
4. Танай систем зөв хамгаалалттай эсэхийг шалгасан үү? Т/Ү/Т-ий
5. Шене ажиллахад аюулгүй юу? Т/Ү/Т-ий

Замын хөдөлгөөн ба аюулгүй явган замыг хүндэлнэ үү!

Анхаар! Та ажлаа эхлүүлэхээс өмнө эдгээр асуулуудад "Тийм-Т", "Үгүй-Ү", "Тохиромжгүй-ТҮ" гэж хариулна уу. Эсхүл ахлагчтай холбогдож, дараагийн арга хэмжээг авна уу.

Халуун нөхцөлд ажиллах

Гал, гагнуур болон халуун зүслэг орсон бүх ажил

Энэхүү зөвшөөрөл тодорхойлсон ажил болон дурдсан хугацаанд хүчинтэй!

Ажлын тодорхойлолт:	Зөвшөөрлийн дугаар:
Ажлын байршил:	
Хэрэглэх багаж хэрэгсэл:	Хүчинтэй (огноо): эхлэх: хүртэл:
Ажил хариуцаж хянах хүн:	Утас:
Зөвшөөрөл олгосон:	Огноо: Цаг:
Зөвшөөрлийг хүлээж авсан:	Огноо:

Боломжит аюул

- | | | | |
|---|---|------------------------------------|-------------------------------------|
| <input type="checkbox"/> Хүчилтөрөгч баяжуулах | <input type="checkbox"/> Хүчилтөрөгч дуусах | <input type="checkbox"/> Toxic Gas | <input type="checkbox"/> Тэсрэх газ |
| <input type="checkbox"/> Био аюул | <input type="checkbox"/> Гэрэлтүүлэг муу | <input type="checkbox"/> Халуун | <input type="checkbox"/> Дуу чимээ |
| <input type="checkbox"/> Салгах / унагах / асаах хэрэгслүүд | | | |
| <input type="checkbox"/> Бусад: | | | |

Хяналтын арга хэмжээ

- | | |
|--|--|
| <input type="checkbox"/> Аюул / Багаж хэрэгсэл тусгаарлагдсан | <input type="checkbox"/> Хэлтсийн ажилчдад мэдэгдсэн |
| <input type="checkbox"/> Хөдөлмөр хамгааллын багаж шаардлагатай: | |

Зайлшгүй мөрдөх аюулгүй байдлын арга хэмжээ

- | | |
|---|--------------------------|
| Ажлын талбайд тохирох гал сөнөөгч байлгах хэрэгтэй | <input type="checkbox"/> |
| Халуун хэмд ажилладаг ажилчдын мэдэх ёстой зүйл | <input type="checkbox"/> |
| (a) Гал гарч байгааг мэдвэл тэд юу хийх ёстойг | |
| (b) Түгшүүрийн дохио хэрхэн дарах | |
| (c) Дүрвэх үйл явц болон цугларах цэгийн талаар мэддэг байх | |
| Бүх талбайг шалгаж, шатах аюултай зүйлийг зайлуулах эсхүл хамгаалж ажлыг эхлүүлнэ | <input type="checkbox"/> |
| Бүх талбайг цэвэрлэж, хамгаалан, шаардлагатай бол олсоор тусгаарлаж, анхааруулсан тэмдэг өлгөнө | <input type="checkbox"/> |
| Ажилтай холбоотой бүх системийг тусгаарлана, галын түгшүүрийн дохиог мөн адил | <input type="checkbox"/> |
| Тухайн ажлын үүрэг даалгаврыг биелүүлэхэд тохиромжтой гал сөнөөгчийг бэлэн байлгахад туслах(хэрэглэхэд сайн дүнтэй) | <input type="checkbox"/> |
| Барилга байгууламжийг менежерт мэдэгдэх | <input type="checkbox"/> |

Ажил дууссанаас хойш **1 Цагийн** дараа талбайг шалгах/шатамхай зүйлийг хянах
Цэвэрлэх зөвшөөрөл авч буцааж өгнө

~~Дээрх ажлын талбайг ажил дууссанаас нэг цагийн дараа шалгасан болно~~

Гарын үсэг (нэр):	Огноо:	Цаг:
Зөвшөөрлийг олгосон хэлтэс	Огноо:	Цаг:
Гарын үсэг (нэр):	Огноо:	Цаг:

8.14 Үйл явдлын бүртгэлийн маягт

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн 1 дүгээр хавсралт

Батлав.....
Хөдөлмөрийн /хөдөлмөрийн эрүүл ахуйн/ хяналтын улсын байцаагч
/тэмдэг дарах/

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫГ ТОГТООСОН АКТ

200... оны ... сарын ... өдөр үйлдэв.

1. Аж ахуйн нэгж байгууллагын нэр:	Байгууллагын хаяг (аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, гудамжны нэр):
2. Өмчийн хэлбэр:	
3. Үйлдвэрлэлийн осол, хурц хорлогод өртсөн хүний овог нэр Төрсөн он.....сар..... өдөр, нас хүйс..... Иргэний үнэмлэхийн дугаар: Нийгмийн даатгалын дэвтрийн дугаар: Албан тушаал: Боловсрол: мэргэжил: Ажилд орсон Он Сар Өдөр, тушаал шийдвэрийн дугаар..... Нийт ажилласан хугацаа үүнээс түс байгууллагад шимтгэл төлж ажилласан.	
4. Байгууллагын захиргаанаас аюулгүй ажиллагааны урьдчилсан зааварчилга авсан байдал:	
5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан: он сар өдөр	6. Эрүүл мэндийн үзлэгт хамгийн сүүлд орсон: он сар.....өдөр
7. Оршин суугаа хаяг:	8. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан:онсар өдөр цагминут
9. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан цех, тасаг, хэсэг, ажлын байрны нэр:	
10. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын байдал /хөнгөн, дунд, хүнд бүлэг, нас барсан :	
11. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын хэлбэр /зур!/: <i>яс хугарах; үе мултрах; зөөлөн эд гэмтэж бяцарсан; тасарсан; зүссэн; гадаад; дотоод гэмтэл; биологи; химийн бодисын үйлчлэл;</i>	
12. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаргахад хүргэсэн шалтгаан, хүчин зүйл:	
13. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас ажилтны эрүүл мэндэд учирсан хохирол:	
14. Комиссын дүгнэлт: Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг гаргахад шууд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгаан, үйл ажиллагааны тухай тодорхой заана:	
15. Комиссын шийдвэр:	

АКТ ТОГТООСОН КОМИССЫН:

ДАРГА /...../

ГИШҮҮД /...../

..... /...../

..... /...../

..... /...../